

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр, Лхагва гараг

	Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
	Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 8
	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9 – 58
1.	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./	10 – 12
2.	Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	12 – 14
3.	Байнгын хорооны тогтоолын төсөл /Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	15
4.	Байнгын хорооны тогтоолын төсөл /Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	16 – 18
5.	Байнгын хорооны тогтоолын төсөл /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	18 – 19
6.	Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн авсантай холбогдуулан хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	19 – 22
7.	Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн саналыг хэлэлцэх/	22 – 33
8.	Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Монгол Улсын ерөнхий прокурорын албан тушаалд томилох саналыг зөвшилцөх тухай асуудал	33 – 58

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 04 дүгээр сарын 09-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 37 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: О.Номинчимэг;

Чөлөөтэй: Х.Баттулга, Л.Мөнхбаатар, С.Одонтуяа, Л.Соронзонболд;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Бат-Амгалан;

Нэг.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар уг хэлэлцэх асуудлаар Байнгын хорооноос хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулж, дараагийн хуралдаанаар хэлэлцүүлье гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Б.Энхбаяр нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 78.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга “Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Д.Цогтбаатар: Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг хариулж, тайлбар хийв.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэв.

Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14

71.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14

57.1 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, М.Нарантуяа-Нара нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 71.4 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх. Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Д.Цогтбаатар: Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 2

Бүгд: 15

86.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх. Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн авсантай холбогдуулан хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх. Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

Д.Цогтбаатар: Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай
/Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн саналыг хэлэлцэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Улсын Их Хурлаас Үндсэн цэцэд хүсэлт гаргах тухай саналыг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай асуудлыг хойшлуулж, дараагийн хуралдаанаар хэлэлцүүлъя гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 6

Бүгд: 15

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, хэлэлцэх асуудлыг хойшлуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Монгол Улсын ерөнхий прокурорын албан тушаалд томилох саналыг зөвшилцөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч Монгол Улсын ерөнхий прокурор, Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх Б.Жаргалсайхан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Монгол Улсын ерөнхий прокурорын албан тушаалд нэр дэвшигчийн танилцуулгыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Д.Ганбат, Ц.Сандаг-Очир, Н.Алтанхуяг, П.Сайнзориг нарын тавьсан асуултад нэр дэвшигч Монгол Улсын ерөнхий прокурор, Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх Б.Жаргалсайхан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Б.Энхбаяр, П.Сайнзориг, Б.Заяабал, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Монгол Улсын ерөнхий прокурорын албан тушаалд Банзрагчийн Жаргалсайханыг томилох асуудлыг Монгол Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 8 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 20 минут үргэлжилж, 22 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 17 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
15 цаг 37 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаа эхэлье.

Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Тэгээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хуралдааны ирц 54.5 хувьтай байна.

Ирсэн гишүүд гэвэл Дамдины Цогтбаатар, Хүрэлбаатарын Баасанжаргал, Дашдондогийн Ганбат, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Бөхчулууны Пүрэвдорж, Ухнаагийн Отгонбаяр, Цэндийн Сандаг-Очир, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Баттөмөрийн Энхбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүдийн ирцтэйгээр ирцийн шаардлага хангагдсан байна.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Өнөөдөр Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудалд байгаа Бусад гэсэн асуудлын хүрээнд хоёр асуудал нэмэгдэж байгаа бөгөөд ингээд хэлэлцэх асуудлыг бүгдийг нь нийлүүлээд хураангуйлаад танилцуулъя.

Нэгдүгээр асуудал. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Хоёрдугаар асуудал. Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл.

Гуравдугаар асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон

хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай санал байгаа.

Дөрөвдүгээр асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай асуудал байгаа.

Тав. Байнгын хорооны тогтоолын төсөл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай асуудал байгаа.

Зургаа. Байнгын хорооны тогтоолын төсөл. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн авсантай холбогдуулан хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай асуудал байгаа.

Ингээд бусад асуудал гээд долдугаар асуудал байгаа. Тэгээд бусад асуудал дотор хоёр дэд хэсэг байна.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай асуудал байна.

Хоёр дахь нь, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Монгол Улсын Ерөнхий прокурорыг томилох саналыг зөвшилцөх тухай асуудал гэсэн ийм асуудлууд өнөөдөр хэлэлцэхээр байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Тэгвэл хэлэлцэх асуудалдаа орёё. Ирцэд Н.Алтанхуяг гишүүнийг нэмж оруулъя. Н.Алтанхуяг гишүүн ярьж ирцдээ орж байна.

Нэг.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Нэгдүгээр асуудал. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг

Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороодод шилжүүлсэн байгаа.

Ингээд Хууль зүйн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Ингээд хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Бид нар дээр оруулж ирээд одоо ярьж байна л даа. Түүнээс манайхаар ч бүр энэ чинь орохгүй. Харин Хууль тогтоомжийн хууль бид бариад байгаа юу чинь ийм байхгүй юу. Дагалдаж орж ирээд л хуулиуд өөрчлөгдөөд байдгийг чинь л хэдүүлээ зогсооё гээд байгаа шүү дээ. Яах вэ? Тийм.

Тэгэхээр хар түрүүний хурал дээр бид хэлэлцэж байхдаа саналуудаа өгөөрэй гээд уг нь ярьж л байсан л даа. Тэгэхдээ санал. Манайхан энэ дээр чинь.

Ингэе ээ, ингэж шийдье. Одоо хэдүүлээ яг сая ярьснаараа ажлын хэсэг байгуулъя. Энэ хэчнээн яаралтай горимоор орж ирж байгаа ч гэсэн Эрүүгийн хуульд нэгэнт өөрчлөлт орох гэж байгаа учраас бид үүн дээр Хууль зүйн байнгын хороо мэргэжлийн түвшинд нарийвчилж хандана гэдэг гишүүдийн ярьж байгаа зарчмын байр суурийг би хүлээн зөвшөөрч байна.

Тэгээд түрүүний хурал дээр бид материалтайгаа танилцаад орж ирээрэй гэсэн ч гэсэн үнэхээр энэ ажлын ачааллаар нэгдүгээрт эд нарыг чинь энэ ингэж тулгамдаж орж ирээд байхад танилцаж амжихгүй байгаа. Би гишүүдийн энэ ажлын ачааллыг ойлгож байгаа.

Хоёрт, уншиж орж ирээд ч гэсэн бид яг ажлын хэсгээрээ нарийвчилж харах нь би зөв гэж үзэж байна.

Тийм учраас ажлын хэсэг байгуулах саналыг гаргаж байна. Тэгээд үүнийг 3 гишүүнээс бүрдсэн, энэ Зөвшөөрлийн хуулийг дагаж орж ирсэн Эрүү, зөрчлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг байгуулж байна.

Түүнд Г.Уянгахишиг гишүүн, Д.Ганбат гишүүн, П.Сайнзориг гишүүн гэсэн гишүүдийгээ оруулаад, Г.Уянгахишиг гишүүнийг ажлын ахлагчаар тавих ийм саналтай байна.

Тэгээд үүнтэй холбогдуулаад, бид ингээд ажлын хэсэг нэгэнт байгуулаад үүнийг хэлэлцэх гэж байгаа учраас, дараагийн хурал дээр манай ажлын хэсэг,

яаралтай горимоор учраас дараагийн долоо хоногийн хурал гэхэд та нар маань хуралдаад юмаа бэлдээрэй.

Тэгээд дараагийн долоо хоногийн хуралд бид даргын дэргэдэх зөвлөлөөр дамжуулаад оруулж ирнэ.

Ингээд хоёр асуудлаар санал хураалт явуулъя.

Нэгдүгээрт, ажлын хэсэг томилж, дараагийн долоо хоногт оруулж ирье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд саналаа өгөөрэй.

64.0 хувиар санал дэмжигдлээ.

Энэ дээр Б.Энхбаяр гишүүнийг дэмжсэнээр, намайг дэмжсэнээр тооцож оруулаарай. Машин ажилласангүй.

Хоёр дахь асуудал нь ажлын хэсгийг Г.Уянгахишиг гишүүнээр ахлуулаад, Г.Уянгахишиг гишүүн, П.Сайнзориг гишүүн, Д.Ганбат гишүүн гэсэн ийм 3 гишүүнтэй ажлын хэсэг байгуулъя гэдэг.

Ажлын хэсгийг саяын уншиж танилцуулсан бүрэлдэхүүнтэй, даргатайгаар байгуулъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

64.3 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд асуудлыг дараагийн долоо хоногийн хуралд оруулж ирэхээр ийм шийд гарлаа.

Одоо хоёрдугаар асуудал руугаа оръё.

**Хоёр.Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг
хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл**
/Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

Хоёрдугаар асуудал. Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл.

Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан санал байгаа юу? Бичгээр гаргасан санал байхгүй байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье. Тэгэхдээ асуулт биш. Үг хэлэх гэж байна шүү дээ. Тийм үү?

П.Сайнзориг: Тийм. Нэг ийм юм байгаа юм. Бид хэд Ерөнхийлөгчийн хориг тавих бүрэн эрхэд, дээрээс нь яг үүнийг дагаж мөрдөх хүмүүсийн нөгөө published хийсэн буюу нийтлэгдсэн тэр хэм хэмжээг дагаж мөрдөх, тэр мэдэх судлах тэр эрхийг нь зөрчиж байна гэдэг агуулгаар цэц нэг шийдвэр гаргачихсан санагдаад байна.

Улсын Их Хурлын зохион байгуулалтын шийдвэр дээр батлагдсан өдрөөс байгаа. Томилгооны шийдвэр дээр батлагдсан өдөр байдаг. Ийм зүйлүүд дээр болно.

Ер нь нийтээр дагаж мөрдөж байгаа хууль, хэм хэмжээнүүдийг заавал published хийсний дараа дагаж мөрдөх асуудал яригдах ёстой гээд байгаа.

Тэгэхээр уг нь энэ хасах саналыг гаргачхаар бас яадаг юм бол. Уг нь яах вэ зүгээр анхны хэлэлцүүлгээр нь баталчихвал уг нь зүгээр байгаад л байна л даа. “Төрийн мэдээлэл” сэтгүүл хэвлэгдээд л ердийн журмаар явах ёстой байхгүй юу. Хасчихвал ердийн журмаар л явчихна гэсэн үг.

Тэгэхээр ийм байдлаар. Яах вэ, хууль санаачлагч энэ дээр юу гэж бодож байна. Та бас нэг хариултаа хэлчхээч. Би бол зүгээр яах вэ, хэдүүлээ яг л Үндсэн хуулийн жишиг зөв зүйлээс нь явчихвал.

Тэгэхгүй энэ батлагдсан өдрөөс гэдэг бол ер нь жоохон буруу байгаа юм. Яах вэ зүгээр Засгийн газрын зохион байгуулалтын томилгоо, шийдвэр дээр бол болоод байгаа юм. Үүнийг бол нэг их түүн дээр гараагүй. Хууль эрх зүйн үр дагавар, дагаж мөрдөж байгаа юмнууд дээр яах юм бол. Та бас энэ дээрээ өөрөө байр сууриа хэлээд явчхаач. Тийм.

Д.Цогтбаатар: Ингэнэ шүү, гишүүд ээ. Одоо сая асуулт асуух юу өгөхөд хэдүүлээ бүртгүүлж.

Энэ чинь яагаад гэвэл цаанаа протокол бүртгэгдээд явж байгаа учраас. Тийм. Асуултад Г.Уянгахишиг гишүүн хариул хариул.

Сая би үг гэж ойлгосон. Г.Уянгахишиг гишүүнээс асуулт асууж байна. Г.Уянгахишиг гишүүний микрофоныг өгье. Асуултад хариулъя.

Г.Уянгахишиг: П.Сайнзориг гишүүний хэлсэн саналыг ойлгож хүлээж авч байна.

Тэгэхээр яах вэ энэ дээр одоо хэрвээ өөрчлөх тохиолдолд энэ дээр чинь яаж өөрчлөлтөө оруулах билээ гэдэг юм байна. Яг энэ зүйл, заалт маань байхгүйгээр өөрөө хүчин төгөлдөр батлагдаад “Төрийн мэдээлэл”-дээ хэвлэгдээд хүчин төгөлдөр үйлчлээд явчихна гэвэл 2 дугаар зүйлийг хасахад асуудалгүй.

Гэхдээ яг процессын хувьд яаж явах ёстой билээ. Түүгээр нь явж болох л юм л даа. Тийм ээ.

Д.Цогтбаатар: Хариулт болсон уу? П.Сайнзориг гишүүн.

Тэгвэл гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ингээд Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Нэгтгээд явуулчихъя гэсэн саналаар. Санал хураалт. /алх цохив/

71.4 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд гишүүнийг тавьчихъя. Л.Соронзонболд гишүүн.

Ингээд дараагийн асуудалдаа орёе.

Сая Өмгөөллийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг хэлэлцэж дууслаа.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Гуравдугаар асуудал. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл.

Байнгын хорооны тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд, үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Үүнийг ингээд нэгтгээд явуулчихъя.

Хууль тогтоомжийн хууль. Алга байна. Ажлын хэсгээс үү? Тэгвэл болно болно. П.Сайнзориг гишүүн.

Тэгэхээр У.Отгонбаяр гишүүн орж болох уу? Энэ Хууль тогтоомжийн хуулийн ажлын хэсэг дээр. Тэгье. Зөв зөв. Тэгэхдээ П.Сайнзориг гишүүн тийм учраас. Би бол нээлттэй байгаа шүү. Энэ дээр.

У.Отгонбаяр гишүүн санаа оноогоо хэлээд. Энд байгаа гишүүддээ хэлээрэй.

Ингээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Та бүгдэд тараасан байгаа. Гэхдээ би уншаад танилцуулъя.

Ажлын хэсгийн ахлагч О.Номинчимэг Улсын Их Хурлын гишүүн. Ажлын хэсгийн гишүүд Ухнаагийн Отгонбаяр, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн ийм 5 гишүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж байна.

Энэ ажлын хэсгийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

57.1 хувиар санал дэмжигдлээ.

Тэгээд М.Наратуяа-Нара гишүүн, Д.Ганбат гишүүн дэмжсэн байна. Дэмжсэн гэж бүртгээрэй.

Ингээд ажлын хэсэг байгуулагдлаа.

Дараагийн асуудалдаа оръё.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх
үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төсөл байгаа.

Тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү Б.Энхбаяр гишүүнээр тасаллаа. Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Би Х.Баасанжаргал гишүүнээр ажлын хэсгийг ахлуулж байгааг дэмжиж байна. Энэ их зөв байна.

Хүний эрхийн асуудлаар бол нэлээн их судалгаа хийж, олон улсын шагнал авсан байх аа. Манай хүний эрхийн Цогтоо гишүүнтэй бас дүйх манлайлагчийн гишүүн гэж бодож явдаг.

Тэгээд энэ ажлын хэсгийн хэлэлцүүлгийн шатад би энэ дагасан хуулиуд дээр бас нэлээн сайн анхаарч сайн үзмээр юм шиг санагдсан. Тухайлбал, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, гэмт хэрэг зөрчлийг бид 2016 онд хуульчилсан. 2016-2020 оны үед Н.Оюундарь гишүүнээр ахлуулаад манай эмэгтэй гишүүд хүчирхийллийн асуудлыг ер нь төр бол хатуу хандах ёстой гэдэг ийм бодлого явуулж байсан.

Тэр ч утгаараа гэр бүлийн хүчирхийллийн зөрчил дээр баривчлах шийтгэлийг оруулж ирж байсан. Маш олон хүмүүс эр, эмийн оронд илжиг ороод, дундаас нь ороод хүнийг баривчлаад байна, шийтгээд байна. Үүнээс болоод айл гэрүүд салж байна гэж ярьдаг юм. Тэгэхдээ би үүнийг нотолсон судалгаа ерөөсөө олж харж байгаагүй.

Засгийн газар бол сэтгэл санаа болон эд хөрөнгийн хүчирхийллийн асуудлыг баривчлах шийтгэлгүй болгоё гэж байгаа юм билээ. Гэр бүл салаад байна гэж үзсэн юм шиг байна лээ. Тэгээд энэ яг хүний эрхийн асуудал уу, үгүй юу гэдгийг тооцоо судалгаан дээр их сайн авч үзээсэй.

Яагаад гэхээр өнгөрсөн 8 жилийн турш бид. Одоо энэ асуудал өмнөх парламентын үед орж ирсэн юм. Тэгээд миний хувьд маш хатуу байсан. Хүчирхийлэлтэй эвлэршгүй байх ёстой. Яагаад гэхээр сэтгэл санаагаар хүнийг амьдын там болгож учруулдаг тийм манекууд бол хаа сайгүй байгаа. Эд хөрөнгийн хувьд хараат байдалд оруулж байна гэдэг чинь мөн тэр хүнийг эрхтэнд халдаж зодохоос илүү хүчирхийлэл байхгүй юу.

Тийм учраас сэтгэл санааны болон эд хөрөнгийн хүчирхийллийг бие махбодын хүчирхийлэлтэй адилтгаж авч үздэг. Тийм.

Тэгэхээр сэтгэл санаагаар нь хүнийг хүчирхийлээд байхад торгоно гэдэг бол би энэ ерөөсөө буруу шийтгэл гэж үздэг.

Тийм учраас би бол баривчлах шийтгэлээр нь байлгах байх ёстой юм болов уу. Энэ чинь түрүүчийн парламент оролдох гэхэд нь бас таслан зогсоосон байхгүй юу. Одоо ингээд гурав дахиа орж ирж байгаа юм. Тэгээд тооцоо судалгаа авч үзэх ёстой.

Миний ойлгож байгаагаар гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг хуульчилсны дараа санаатай хүн амины гэмт хэргийн тоо Монгол улсын түүхэнд анх удаа буурсан байхгүй юу. Энэ бол эерэг үр дүн.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр гишүүн үг хэллээ.

Би үүнтэй холбогдуулаад Х.Баасанжаргал гишүүнд ер нь энэ ажлын хэсгийг даргалаад явж байхдаа нэг өнцгийг бас харж байгаарай гээд. Тэгээд дараа нь тусдаа асуудлаа бас оруулж ирж болох байх.

Энэ Зөрчлийн хуульд ажлын байрны дарамт гэдэг ойлголтыг Зөрчлийн хуульд Эрүүгийн хуулиас оруулчихсан юм билээ. Тэгээд түүнээс болоод ер нь нөхцөл байдал одоо ингээд жендэрийн асуудал эрхэлсэн олон төрийн бус байгууллагууд энэ асуудлыг яриад байгаа юм.

Тэгэхээр үүн дээр Х.Баасанжаргал гишүүн хүний эрхийн л асуудал яригдаж байгаа юм чинь давхар та нэг судлаад үзээрэй.

Тэгээд тэр Зөрчлийн хуульдаа байгаад байгаа нь зөв юм уу, буруу юм уу. Үүнээс хойш зөрчлүүдийн тоо, статистик яаж өөрчлөгдсөн байна нэг харсан байх нь бас зөв байж магадгүй шүү гэдгийг зүгээр давхар энэ завшааныг ашиглаад хэлчихье гэж бодож байгаа юм.

Ингээд ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулахаар байгаа.

Ажлын хэсгийн ахлагч Х.Баасанжаргал гишүүн. Ажлын хэсгийн гишүүд Ж.Алдаржавхлан гишүүн, М.Нарантуяа-Нара гишүүн, П.Сайнзориг гишүүн,

Ц.Сандаг-Очир гишүүн, Х.Тэмүүжин гишүүн, Г.Уянгахишиг гишүүн гэсэн ийм гишүүдийн бүрэлдэхүүнтэй, 7 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгаа.

Ингээд ажлын хэсэг байгуулах Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

86.7 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн асуудалдаа оръё.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Тавдугаар асуудал. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай.

Байнгын хорооны тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү.

Да.Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Да.Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Да.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Энэ ажлын хэсгийн гишүүд дээр би орж болох уу?

Д.Цогтбаатар: Болно.

Да.Цогтбаатар: Орох саналтай байна.

Д.Цогтбаатар: Тэгэхээр дараах бүрэлдэхүүнтэй байгаа.

Ажлын хэсгийн ахлагчаар П.Сайнзориг гишүүн, Улсын Их Хурлын гишүүн. Ажлын хэсгийн гишүүд Н.Алтанхуяг гишүүн, Э.Бат-Амгалан гишүүн,

Х.Баасанжаргал гишүүн, М.Нарантуяа-Нара гишүүн, У.Отгонбаяр гишүүн, Ц.Сандаг-Очир гишүүн, Х.Тэмүүжин гишүүн. Тэгээд сая сүүлд Да.Цогтбаатар гишүүн оръё гэсэн хүсэлтийн дагуу ингээд орууллаа.

Ингээд тогтоолын төслийг саяын уншиж танилцуулсан бүрэлдэхүүнээр баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

73.3 хувиар санал хураалт дэмжигдлээ.

Дараагийн асуудалдаа оръё.

Зургаа.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн авсантай холбогдуулан хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Бусад асуудал гээд хоёр асуудал байж байгаа. Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналтыг хэлэлцэх тухай.

Уучлаарай. Зургадугаар асуудал. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг Улсын Их Хуралд хүлээн авсантай холбогдуулан хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай.

Тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Нэгтгээд явуулж байна. Д.Ганбат гишүүнээр тасаллаа. Д.Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Нэгэнт цэцийн тогтоолыг хүлээж авсантай холбогдуулаад ажлын хэсэг байгуулж байна.

Ц.Сандаг-Очир гишүүний ахлуулдаг нь зөв өө. Б.Заяабал гишүүн орсон байна. Ер нь их боломжийн орчихсон байна.

Тэгээд энэ дээр ийм л байдаг л даа. Одоо шүүгчээр ажиллах хүн маань жилийн жилд л цөөрөөд байгаа л даа. Тийм. Тэгээд уг нь миний баримталдаг зарчим ч тэр. Ардчилсан улс орнууд шүүгчийг бүх насаар нь сонгодог ийм байдаг. Манайх ардчилсан орон. Тэр зарчимдаа л давуу байх байтал яагаа ч үгүй тэр насаар нь хязгаарлачихсан. Тэр арай болмооргүй байгаа юм. Тэрийг ч Улсын Их Хурал хүлээгээд авчихлаа.

Тухайлбал, эмэгтэй хүн 50, 55 насандаа байна уу. Тэгж гараад байгаа байхгүй юу. Шүүхийн ажил дадлага, туршлага, олон жил сургадаг ийм онцгой ажил.

Тэгээд ч бүх насаар нь болдоггүй юм бол хангалттай хугацаанд ажиллах тийм боломжийг нь олгох хэрэгтэй. Жилээс жилд монголчуудын дундаж нас уртсаж байна. Одоо бараг 70 хүрч байгаа байх. Тийм ээ. Эмэгтэйчүүд чинь эрэгтэйчүүдээсээ бүр 10 насаар ч ахиу байгаа байх гэх мэтчилний ийм зүйлүүд байгаа.

Тэгэхээр зарим нэг зүйл дээр шүүх дээр очоод бас олон нийтийн шүүмжлэл нэлээн гарч байна. Тухайлбал, 2012-2016 онд авлигатай тэмцэх индексээр бид чинь 72-т орчихсон байна лээ шүү дээ. Одоо тэгсэн чинь одоо 120-н хэдэд явж байна.

Энд туршлагатай, мэдлэгтэй, боловсролтой ийм шүүгч нар л асуудлыг шийднэ шүү дээ. Тийм.

Тэгэхээр энэ ажлын хэсэгт би өөрийгөө орох нь зүйтэй юм гэж бодож байна. Намайг оруулчхаарай. Орох хүсэлтэй байна.

Д.Цогтбаатар: Тэгээд Д.Ганбат гишүүнийг оруулъя гэсэн саналыг дэмжиж байна.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Ажлын хэсгийг бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Тэгэхээр ажлын хэсгийг Ц.Сандаг-Очир гишүүнээр ахлуулж байгуулж байна. Тэгье. Тэгээд ажлын хэсгийн гишүүд М.Нарантуяа-Нара гишүүн, Б.Заяабал гишүүн, Д.Ганбат гишүүн, Л.Соронзонболд гишүүн болж байгаа.

Ингээд 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсгийг байгуулж байна.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

73.3 хувиар санал дэмжигдлээ.

Тэгээд үүнтэй холбогдуулаад харин би гишүүддээ нэг зүйл хэлмээр байна.

Хууль зүйн байнгын хорооны гишүүддээ бас талархал илэрхийлмээр байна. Төсөв хэлэлцүүлгийн үеэр ялангуяа шүүхийн байгууллагын төсөв бол яах аргагүй манай Байнгын хороон дээр ирж зангидагдаж шийдэгддэг. Бусад байгууллагаас ялгаатай нь шүүхийн хуулиараа ерөөсөө тийм.

Ингээд бид төсөв дээр нь үнэхээр санаачилгатайгаар ажилласан. Тэгээд өчигдөр, уржигдар Дархан хотод очиж батлагдсан төсвийн бодит хэрэгжилт эхэлж байна. Шүүхийн барилгууд эхэлж байна.

Ингээд Дархан хотод шүүхийн барилгын шав тавих ёслолд ороод ирлээ.

Тэгээд та бүгддээ зүгээр л уламжлаад хэлэхэд нээрээ олон жил энэ шүүх дээр төсөв огт тавигдаагүй байсан. Би газар дээр нь нөхцөл байдалтай нь очиж танилцлаа.

Манай Улаанбаатарын зарим шүүхүүд маш хүнд байгаа. Тэнд бас адилхан хүнд байхаас гадна өшөө нэг сонин юм нь юу байна гэхээр бид энд чинь танилцуулгаар л яриад л, танилцуулгаас л яриад байгаа болохоос биш би яг очиж нүдээрээ үзлээ.

Гадаад улсын Засгийн газрын мэдлийн өмчийн байранд, Монгол төрийн өөрийнхөө газар нутаг дээр хүний төрийн байранд Монголын шүүх түрээс төлөөд 30 хэдэн жил явчихсан байж байгаа байхгүй юу.

Одоо тэгээд энэ байдал зогсох гэж байгаа юм. Үнэндээ би зүгээр тэнд явж байгаад жишээлбэл энэ чинь нөгөө өөр улсын төрийн мэдэлд байгаа болохоор дипломат статустай юу, үгүй юу гээд л асуудал шууд гарч байгаа байхгүй юу.

Хэрэв дипломат статустай байвал тэр барилга дотор байгаа юрисдикц чинь Монголын юрисдикц биш болоод явчихна шүү дээ. Тэгтэл Монголын юрисдикц биш газар Монголын шүүх ажиллаад өөрийнхөө хуулийг хэрэгжүүлэх шийдвэрүүд гаргаад яваад байгаа. Өөрөө ингээд эрх зүйн аягүй олон зөрчилтэй сонин нөхцөл байдал бүрдэж байгаа байхгүй юу.

Тэгээд үүн дээр манай Байнгын хороо үнэхээр санаачилгатай ажиллаж, аягүй том өөрчлөлт гарч байгаа юм билээ шүү.

Одоо үүний дараа Архангайд, Өмнөговьд, Говь-Алтайд энэ шүүхийн барилгууд баригдана. Тэгээд шүүхийн барилга гэхээр хүмүүс ийм юм бодоод байх шиг байгаа юм. Нэг шүүгчдийг тухтай ажиллуулах тухай яриад байх шиг байгаа юм. Үгүй. Энэ чинь хамгийн гол нь иргэдийн эрх, шударга шүүхийн өмнө маргаанаа шийдвэрлүүлж байх иргэдийн эрх зөрчигдөөд байгаа байхгүй юу.

Энд оруулж байгаа хөрөнгө оруулалт чинь иргэд рүү чиглэсэн, иргэдийн эрхийг найдвартай хамгаалах ийм хөрөнгө оруулалт хийгдсэн байгаа шүү.

Тэгээд энэ ажил их бодитой маш хурдтай явж байна лээ. Шүүхийн ерөнхий зөвлөл үнэхээр доор нь асуудлуудаа газар дээр нь шийдээд явсан байна лээ.

Тэгээд ажил эхэлж байгаа гэдгийг мэдэгдье. Тэгээд гишүүддээ бас талархал илэрхийлье.

Ингээд долдугаар асуудалдаа оръё. Бусад асуудал гэж байж байгаа.

Долоо.Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай
/Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн саналыг хэлэлцэх/

Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингээс 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Улсын Их Хурлын даргад өргөн барьсан санал байгаа.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингээс Улсын Их Хурлын даргад 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах ийм санал ирүүлсэн байгааг хэлэлцье.

Саналын талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин танилцуулна. Х.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Үндсэн хуулийн цэцэд яагаад ийм хүсэлт хүргүүлэх болсон бэ гэхээр нэг ийм кэйс тохиолдол гарсан.

Үндэсний аудитын даргаар ажиллаж байсан нэг иргэн Улсын Их Хурлаас Үндсэн хууль дээр байгаа Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагын даргыг томилох болон огцруулах эрх мэдэл Улсын Их Хурлын хэнтэй ч хуваалцахгүй бүрэн эрх байгаа.

Тэгээд энэ бүрэн эрхийнхээ дагуу шийдвэр гаргасан байсан чинь уг иргэн энэ шийдвэртэй холбоотойгоор шүүхэд гомдол гаргасан.

Захиргааны шүүх энэ бол шүүхийн асуудал биш байна гээд аваагүй. Иргэний шүүх энэ бас шүүхийн асуудал биш байна гээд аваагүй.

Тэгээд Дээд шүүхэд гомдол гаргасан. Дээд шүүх бас энэ шүүхийн асуудал биш байна гээд бас буцаасан.

Тэгсэн чинь Үндсэн хуулийн цэцэд бас гомдол гаргасан. Үндсэн хуулийн цэц энэ цэцийн асуудал биш байна гээд буцаасан гэх мэтчилэн хэд хэдэн удаа тойрог шиг асуудал явсан юм билээ.

Тэгээд цэцэд хоёр дахь удаагаа очсон чинь цэцээс ямар шийдвэр гарсан бэ гэхээр бид 1992 оны Үндсэн хуульд батлаад 1994 онд Цэцийн тухай хууль тогтоомж хийхдээ тэнд Үндсэн хуульд байхгүй эрх хэмжээг цэц дээр биччихсэн.

Тэр нь юу вэ гэхээр харьяалал нь тодорхойгүй шүүхийн маргааны шүүхийн харьяалал гэж тогтоож өгнө гэсэн утгатай зүйл биччихсэн юм билээ. Тэгээд сүүлд Шүүхийн тухай хууль дээр энэ бол шүүхийн асуудал байгаа учраас Дээд шүүхэд энэ харьяалал тодорхойгүй маргааны шүүхийн харьяалалыг тогтоож байх эрх мэдлийг биччихсэн. Тэгээд тэнд давхацсан ийм хоёр зохицуулалт зэрэгцээд явж байсан.

Тэгээд Үндсэн хуулийн цэцээс харьяалал тогтоогоод захиргааны шүүх рүү шилжүүлчихсэн юм байна. Захиргааны шүүх анхан шатын шүүх авч хэлэлцээд бас энэ шүүхийн маргаан биш гээд буцаачихсан юм байна.

Тэгсэн чинь давж заалдах шатын шүүх нь анхан шатынхаа шүүхийн шийдвэрийг хүчингүй болгоод анхан шатдаа шийд гээд өгчихсөн чинь анхан шатын шүүх нь маргаан үүсгээд одоо Улсын Их Хурлаас нотлох баримт хүргүүл гэдэг ийм шүүхийн захирамж гараад ирж байгаа байхгүй юу.

Энэ дээр Үндсэн хуулийн маргаан гарч байна.

Улсын Их Хурал буюу хууль тогтоох байгууллага нийтийн захиргааны байгууллага шиг захиргааны шүүхэд дуудагддаг болчхож. Яг захиргааны байгууллага шиг шүүхэд нотлох баримт гаргадаг болох гэж байна.

Гэтэл Үндсэн хууль дээр хууль тогтоох эрх мэдэл гагцхүү Улсын Их Хуралд хадгална. Улсын гадаад, дотоод байдлыг авч хэлэлцэх эрхтэй. Тэгээд бүр бүрэн эрх дотроо ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагынхаа даргыг томилох болон огцруулах бүрэн эрхтэй.

Тэгэхээр Үндсэн хуулийн бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлсэн талаарх шүүхийн маргаан явдаг болно гэдэг бол хууль тогтоох байгууллага гүйцэтгэх эрх мэдэл шиг, Засгийн газар шиг болж байна гэсэн үг байхгүй юу.

Энэ Үндсэн хуулийн үндсэн суурь зарчимтай зөрчилдсөн ийм кэйс гараад, тэгээд ер нь энэ цэцийн хууль тогтоомж дээр байгаа энэ заалт Үндсэн хуулийн агуулгатай зөрчилдөж байгаа юм байна. Энэ заалтыг хэрэгжүүлэх гэж оролдсон Цэцийн шийдвэр зарим талаараа Үндсэн хуулийн бус тийм үр дагавар үүсгэж байгаа юм байна гээд. Тэгээд цэц рүү ямар нэгэн байдлаар энэ шийдвэртэй нь

холбоотойгоор ямар нэгэн гарц, гаргалгаа хийх хэрэгтэй болоод ийм цэцийн хүсэлтийг явуулж байгаа.

Энэ хүсэлттэй холбогдуулаад энэ хуулийн заалтын агуулга нэг тийшээ шийдэгдэх байх. Нөгөөтээгүүр цэц гаргасан шийдвэрээ цэц өөрөө л хүчингүй болох ёстой учраас тэр харьяалал тогтоосон шийдвэр нь тэндээ шийдэгдэх байх гэдэг ийм хүлээлт, ойлголцлоор энэ асуудал хөндөгдөж байгаа. Гол агуулга нь ердөө энэ.

Д.Цогтбаатар: Тэгээд энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан санал гаргасан гишүүнээс асуулт асуух гишүүд нь нэрээ өгнө үү.

П.Сайнзориг гишүүнээр тасаллаа. Г.Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Үндсэн хуулийн цэцэд Үндсэн хууль зөрчсөн асуудлаар Улсын Их Хурлаас хүсэлт гаргаж байсныг би сайн мэдэхгүй байна. Энэ анхных байх аа. 33 жилийн түүхэнд.

Улсын Их Хурал хүсэлт гаргасан тохиолдолд цэц маргаан үүсгэх эсэх асуудлыг хэлэлцэхгүй шууд маргаан үүсгэнэ. Шууд их суудал хуралддаг санагдаж байна. Дунд суудал гэж байхгүй. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурал хүсэлт гаргавал тусгай дэгээр явдаг. Шууд эцсийн шийдвэр гардаг. Буцаж Улсын Их Хурал дүгнэлт гараад тэрийг нь хэлэлцэнэ гэсэн асуудал байхгүй. Нэг.

Тийм учраас энэ асуудлыг би нөгөө агуулга руу нь сайн. Энэ чинь дөнгөж сая тараагдаад уншаад байгаа учраас уншиж дуусаагүй байна. Ний нуугүй хэлэхэд.

Х.Тэмүүжин, энэ чинь бас хууль санаачлах, тогтоол санаачилж байгаатай адил асуудал байхгүй юу. Энэ чинь Үндсэн хуулийн цэцийн шууд эцсийн шийдвэр гаргах хууль, улс төрийн үр дагавартай асуудал хэлэлцээд байгаа байхгүй юу Хууль зүйн байнгын хороо.

Тийм учраас нэгдүгээрт гишүүдэд танилцаж судлах боломж олгооч ээ гэж хүсэх гэж байна. Хэрвээ болж өгвөл бүр ажлын хэсэг гаргачихвал зүгээр байх. Байнгын хорооноосоо. Х.Тэмүүжин гишүүний хэлэлцүүлж байгаа санал дээр.

Би бол яагаад яриад байна вэ гэхээр энэ жишээлбэл 2021 онд баталсан Шүүхийн тухай хуулийн заалт Үндсэн хууль зөрчсөн тухай хүсэлт өгөх гээд байна гэх. Айн. Биш юм уу? Харин уншиж дуусаагүй болохоор чинь ингээд байгаа байхгүй юу. Ийм олон хуудас. Харин тийм.

Тэгэхээр үүнийг би одоо юу явчлав. Үүний цаана юу байна. Үүний цаана ямар хэрэг байна вэ. Юу хувь заяа нөлөөлөх гээд байна вэ гээд л. Тэгсэн чинь

томилгоо руу ч орох гээд байгаа юм шиг. Энэ хүний асуудал яригдах гээд байна уу гээд улс төрийн хардлага үүсээд л бодоод л, бодлого бодоод л.

Х.Тэмүүжингээ ч арай тэгж хардахгүй байгаа. Тэгэхдээ хэний зараалаар юу хийх гээд байна, томилгоо гээд л бодож эхэлж байна шүү дээ энэ чинь. Одоо хартай авгай шиг л болчихдог юм байна шүү дээ.

Тэгээд ийм боломж олгож өгөөч гээд. Нэг долоо хоног. Хэрвээ нэг ажлын хэсэг гаргавал би шууд ахалмаар байна. Өөрөө.

Д.Цогтбаатар: Юу ч гэсэн Х.Тэмүүжин гишүүнд микрофон өгье.

Х.Тэмүүжин: Захиргааны шүүх дээр маргаан үүссэнтэй холбоотойгоор хуулийн хугацаанууд явж байгаа.

Улсын Их Хурлаас нотлох баримт гаргуулах хүсэлт нь шүүгчийн хүсэлт ирчихсэн. Тэр хугацаанууд нь хэтрээд сая энэ долоо хоногт байсан байх. Шүүх хурал нь болох байсан. Улсын Их Хурал дээр ийм үйл ажиллагаа явж байгаа учраас гээд шүүх хуралдаан нь хойшилсон.

Тэгэхээр цаг хугацааны хувьд шахагдаад явж байгаа гэдэг зүйлийг ойлгоорой.

Шүүхийн тухай хуулийн тэр заалт биш. Шүүхийн тухай хуулийн тэр заалттай давхацсан байдлаар 1994 онд бичсэн цэцийн тухай хууль дээрх тэр заалтыг хөндөж байгаа. Агуулга нь.

Аудиттай холбоотой, яг албан тушаалтантай холбоотой гэх юм бол энэ кэйс нь болохоор 2016-2019 оны хооронд байсан уу, аудитор байсан хүнтэй холбоотой. Д.Хүрэлбаатар. Тийм.

Тэгээд юу болж байгаа вэ гэхээр яг энэ кэйс хэрвээ шүүхээр ороод явдаг нэг ийм сонин тохиолдол гарчих юм бол цаашдаа Улсын Их Хурал дээр жишээ нь ийм юм болж эхэлнэ.

Үндсэн хуулийн цэцэд томилогдох гэж байгаа нэг хүн орж ирээд Улсын Их Хурал олонхоороо асуудлыг шийднэ. Тийм ээ. Нөгөө хүн дэмжлэг авахгүй уначихлаа гэхэд Улсын Их Хурал миний асуудлыг шийдсэнгүй гээд шүүх рүү ханддаг болж эхэлнэ.

Хариуцлага тооцогдож байгаа Улсын Их Хурлын хэнтэй ч хуваагдашгүй бүрэн эрх хариуцлага тооцоод хэн нэгнийг огцруулахад тэр хүн шүүхэд гомдол гаргаад Улсын Их Хурлыг шүүхэд дуудаад асуудлаа шүүхээр шийдүүлэх гэж оролддог болж эхэлнэ.

Өөрөөр хэлбэл Улсын Их Хурал цэцэд биш захиргааны, иргэний шүүхэд дуудагддаг болж эхэлнэ гэсэн үг байхгүй юу.

Үндсэн хуулиар ийм боломж огт байхгүй. Угаасаа эрх мэдэл хуваарилалтын зарчмаар үүнийг зөвшөөрдөггүй. Уг хүн нь яагаад аудитаас чөлөөлөгдсөн гэдгийг та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа байх. Тэр үед би Улсын Их Хурлын гишүүн байгаагүй.

Монгол Улсын ерөнхий аудитор төсвийн сахилга бат дээр хяналт тавих ёстой хүн сонирхлын зөрчлийн хуулиар Засгийн газар буюу төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч огт байж болохгүй хориотой байсан этгээд өөрөө жижиг, дунд үйлдэрлэлийн сангаас зээл авсан.

Энэ асуудал дээр Авлигатай тэмцэх газар дээр шалгагдаж байсан. Тэгээд яг энэ асуудлаараа албан тушаалаасаа чөлөөлөгдсөн. Одоо шүүхдээд явж байна.

Д.Цогтбаатар: П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би Х.Тэмүүжин гишүүнээс хоёр асуулт асуумаар байна.

Нэгдүгээрт, та яг цэцэд ингэж хүсэлт гаргаж байхаар асуудлуудыг мэдэж байгаа юм чинь шууд хуулийн төсөл боловсруулаад явчихвал яасан юм бэ гэдэг санал байна. Өөрөөр хэлэх юм бол нэгэнт та Үндсэн хууль зөрчсөн ийм заалт цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль дээр байгаа учраас энэ асуудлыг эцэслэн нэг талд нь гаргана гэдгийг цэцээр биш өөрөө бас хууль санаачлах эрхтэй гишүүний хувьд хууль санаачлах бүрэн бололцоо байгаагүй юу. Ингэж явах арга зам нь ямар учиртай юм бэ гэдэг дээр та нэг тайлбар хэлээч.

Энэ анхны жишиг гарах гээд байна шүү дээ. Бидэнд хууль санаачлах эрх байгаад байна. Үүнийг хэлчихмээр байна.

Хоёрдугаарт, Х.Тэмүүжин гишүүний юун дээр бас хууль зүйн техникийн нэлээн олон юмнууд байна л даа. Хуулийн заалтыг практикт хэрэглэхдээ сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийг илүү их нарийвчилдаг практик тогтлоо энэ тэр гээд.

Би үүнийг хаана тогтож байгааг мэдэхгүй байна. Тэгэхдээ ер нь Улсын Их Хурлын хариуцлагатай гишүүний юун дээр бас ингэж явмааргүй байна.

Иргэний хууль дээр хууль хэрэглээний зарчим бол ингэж тогтож байгаа боловч бусад хууль дээр бол ингэж тогтохгүй байгаа. Манай жишээ нь Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулийн чинь ерөнхий анги тэр чигтээ хууль хэрэглээ байхгүй юу. Ерөөсөө л яаж хэрэглэх вэ гэдэг асуудал.

Тэгэхээр бид хэдийн нийтийн эрх зүй дээр бол ийм сүүлд батлагдсан хууль нь давуу хүчинтэй шүү гэдэг юм ерөөсөө олон нийтэд өгч болохгүй ээ. Энэ дээр гишүүдийг анхаараач ээ гэж хүсэж байгаа юм.

Тэгээд ер нь цаашдаа энэ дээрээс юу харагдаж байна гэхээр хууль батлах эрэмбэ болоод ерөнхий хууль, тухайлсан хуулиудын нөгөө эрэмбийн асуудлыг бид маш зөв сайн хууль боловсруулж томъёолж өгөхгүй бол хууль тогтоомж тэрнээс бүрдэнэ гээд биччихээд байдаг. Тэрний чинь цаана энэ зүйлүүд яваад байгааг бид орхигдуулаад байгаа.

Тэгэхээр эхний тэр асуултад хариулаад өгөөч ээ гэж байгаа юм.

Сүүлийн зүгээр нэг хэлэх юм байна. Х.Тэмүүжин гишүүний ярьж байгаа юм бол бодитой байгаа шүү дээ. Одоо ч үүсчихсэн.

Монгол Улсад хэм хэмжээний акт буюу захиргааны хэмжээний акт 5 төрөл байгаа. 5 төрлийн нэг нь хууль тогтоох буюу Улсын Их Хурлаас Байнгын хороондоо эрх мэдлээ шилжүүлчихсэн юмнууд байдаг байхгүй юу. Жишээ нь, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хуулиар ашиг сонирхлын мэдүүлэг буюу ХАСХОМ гаргах этгээдийн жагсаалтыг батлаад, хэм хэмжээ буюу үндсэндээ энэ чинь захиргааны хэмжээний акт буюу бүртгэлгүй явдаг акт байхгүй юу.

Энэ дээр маргаан үүсгээ гэвэл бараг Байнгын хорооны шийдвэр учраас цэц дээр авдаггүй, Захиргааны шүүхээр явахаас өөр аргагүй байдалд байхыг бас үгүйсгэхгүй.

Тийм учраас эрх мэдлийг шилжүүлэх буюу POWER OF DELEGATION гэдэг энэ хууль зүйн техник ашиглалтаа хэнд шилжүүлэх вэ гэдэг зүйлээ бодохгүй байх юм бол бид хэд Х.Тэмүүжин гишүүний хэлж байгаа шиг ийм эрсдэлүүд буюу парламентынхаа нэг сегмент болох Байнгын хороогоо ч захиргааны хэргийн шүүх дээр дуудуулах нөхцөл байдлыг аль хэзээ үгүйсгэчихсэн юм. Үүнийг засаж залруулах шаардлага байгаа юм.

Тэгэхээр энэ явц дундаа бол үүссэн шүү дээ. Захиргааны хэргийн шүүхээс чинь бид нарын хууль хэлэлцсэн тодорхой шийдвэрүүдийг гаргаж ирүүлж бүр тайлбар авхуулах бичиг ирж байсан. Бүр Тамгын газрын даргаар. Нэр бүхий.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Тийм. Асуулт. Та нэмээд асууж болно. Х.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Ер нь бид хэд Нийтийн захиргааны эрх зүй Үндсэн хуулийн эрх зүй хоёр ойрхон байж магадгүй. Зарим талаараа ингээд давхцах тохиолдол гарна.

Гэхдээ нөгөө шилжилт, эрх мэдэлд шилжүүлж байгаа энэ шилжилтийнхээ юман дээр хууль тогтоогч хууль тогтоох эрх мэдэл дотор байгаа бүтцийнхээ чиг үүргийг бид шууд захиргааны хэм хэмжээ, эсвэл захиргааны субъект болгож харах бол бас өрөөсгөл байх.

Засгийн газар буюу гүйцэтгэх эрх мэдэл рүү шилжүүлж байгааг бол ойлгож байна. Болно.

Улсын Их Хурлаас мандат авч байгаа, парламентаас мандат авч байгаа бие даасан байдлаар хяналт хэрэгжүүлдэг байгууллагууд руу шилжүүлж байгааг бол ойлгож байна.

Хууль тогтоох байгууллагын дотоод зохион байгуулалтынхаа хувьд үүнийг шууд нийтийн захиргаа буюу захиргааны гэж хэлэх зовлонтой. Энэ бол өөрөө Үндсэн хуулийн асуудал гэдгийг ойлгох байх. Нэгдүгээр асуулт.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Г.Уянгахишиг гишүүн асуултаа асууя.

Г.Уянгахишиг: Ерөнхийдөө энэ асуудал дээр Б.Энхбаяр гишүүний хэлснийг дэмжиж байна. Бид хэд одоо яг шууд танилцаж яг хэргийнхээ гол асуудлууд руу бас орж асуултаа асуух ч гэдэг юм уу, дүгнэлт гаргахад хэцүү байна л даа.

Яг энэ асуудлыг илүү тодорхой болгох үүднээс гурван асуулт асуумаар байгаа юм. Х.Тэмүүжин гишүүн ээ.

Нэгдүгээрт, саяын тайлбараас харах юм бол цэц харьяалал тогтоох эрхгүй гэж тайлбарлаж байна. Тийм ээ. Тэгэхдээ хууль дээр цэц харьяалал тогтоогоод байна гээд. Нөгөө талдаа Шүүхийн тухай хуулиар Улсын дээд шүүх харьяалал тогтоох эрхтэй байна гээд ийм хоёр давхацсан заалт байгаад байна.

Тэгэнгүүт одоо миний асуух гээд байгаа асуулт болохоор сая ингээд хэргийн нюанс гаргаад ярихаар цэцээс харьяалал тогтоогоод шүүх дээр оччихсон. Тэгэхдээ энэ ер нь шүүхээр хэлэлцэгдэх ёстой юу, үгүй юу гэдэг асуудал яригдаад байна шүү дээ.

Тэгэхээр Дээд шүүхээс харьяалал тогтоочихсон бол тэр бас л болохгүй гэдэг тухай асуудал гарах гээд байна. Тийм үү?

Тэгэхээр би асуудлаа хооронд нь ялгах гээд байхгүй юу. Салгаж ойлгох гээд байхгүй юу. Өөрөөр хэлэх юм бол ер нь хуулиар яг аль шүүхээр шийдвэрлэгдэх ёстой вэ гэдэг хэрэг маргааны шүүхийн харьяалал тогтоогдохгүй байгаа асуудал дотор энэ хүсэлт, энэ бичиг дотор, одоо бид нарын хэлэлцээд

байгаа асуудал дотор байгаа үйл явдал маань хамаарчхаад байгаа юм байна гэдэг үндэслэлээр цэцээс нөгөө харьяалал тогтоолгочихжээ. Тэгвэл яг энэ асуудлаараа Улсын дээд шүүхээс харьяалал тогтоолгож болох байсан уу, үгүй юу гэдэг нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт нь, хэрвээ Улсын Дээд шүүхээс харьяаллын бас яг ингээд Захиргааны хэргийн шүүх рүү байна гээд тогтоочихсон бол яах байсан бэ гэдэг асуудал үүсэж гарч ирээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр эндээс ерөөсөө гол асуудал нь яг энэ Их Хурлаас томилдог, Их Хурлаас чөлөөлдөг албан тушаалтнуудын хувьд шүүхэд гомдол гаргах эрх байдаг юм уу, байдаггүй юм уу? Энэ нь ямар хуулиар зохицуулагдах ёстой юм. Энэ нь тодорхой байна уу, үгүй юу гэдэг дээр бас асуулт тавимаар байгаа юм. Өөрөөр хэлбэл хэрвээ бид тэр шүүхийн харьяалал тогтоосон, тогтоогоогүй гэдэг бол хэн нэг нь тогтоож л таарах болчихоод байна шүү дээ.

Тэгэхээр гол асуудал маань энэ маргаан өөрөө шүүхээр орох ёстой байсан уу, үгүй юу? Улсын Их Хурлын хурал өөрөө захиргааны хэргийн шүүх дээр хариуцагчаар орох ёс боломжтой юу, боломжгүй юу гэдэг асуудал гарч ирээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ тал дээр Х.Тэмүүжин гишүүнээс тайлбар авмаар байна.

Тэгээд яг энэ хүсэлтийн маань гол. Хүсэлт чинь нэг гол хүсэлт нь байх ёстой шүү дээ. Тэгэхээр яг тэр нь юу юм бэ? Үүнийг бас тодруулж асуумаар байна.

Д.Цогтбаатар: Х.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Энэ яах аргагүй Үндсэн хуулийн суурь, Үндсэн хуулийн дэг журамтай л холбоотой асуудал хөндөгдөж эхэлж байгаа юм.

Хууль тогтоох эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдэл, шүүх эрх мэдэл хоорондын одоо CHECKS AND BALANCES гэдэг энэ харилцан хяналтын төсөлтэй байх зарчим байхгүй юу.

Энэ зарчмыг дээд шүүх нь Америк шиг Үндсэн хуулийн шүүхийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг байсан бол одоо дээд шүүх хууль тогтоох байгууллагын асуудлыг шийдчихэж болох байх. Манайх бол дагнасан, бие даасан Үндсэн хуулийн шүүхтэй буюу Үндсэн хуулийн цэцтэй болсон.

Тэгээд Үндсэн хуулийн цэц бол Улсын Их Хуралтай холбоотой асуудлыг Үндсэн хууль зөрчсөн байна уу, үгүй юу гэдгийг тийш нь шийдэж байгаа. Тэндээсээ салгаад ердийн шүүх гэдэг “эрүү”, “захиргаа”, “иргэний шүүх” байж байгаа.

Энэ 3 шүүх хууль тогтоох эрх мэдлийн асуудлаа авч хэлэлцэж ерөөсөө болохгүй. Зарчим нь ерөөсөө. Хууль тогтоох эрх мэдэл дотор чинь юу байгаа вэ гэхээр нэг талаасаа хууль тогтоох эрх байгаа. Нөгөө талаасаа хуулийн биелэлтийг хянах эрх мэдэл байгаа. Нөгөө талаасаа Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг, эсвэл парламентын мандатаар парламентын хяналтыг бие даасан байдлаар хэрэгжүүлдэг, эсвэл IMPEACH хүрээнд өртдөг энэ субъектүүдтэй холбоотой хариуцлага тооцдог эрх мэдэл байж байгаа.

Энэ хариуцлага тооцдог энэ эрх мэдлийг хэрвээ Үндсэн хууль зөрчсөн байна гэвэл цэц л авч хэлэлцэнэ. Өөр шүүх авч хэлэлцэж ерөөсөө болохгүй. Үндсэн хуулийн хуваарилалтынх нь гол зарчим чинь энэ шүү дээ.

Гэтэл одоо манайд юу болж байна вэ гэхээр Улсын Их Хурлын шийдвэрийг Захиргааны шүүх рүү өгч болох уу, ердийн шүүх рүү шийдэж болох уу гэдэг ийм асуудал хөндөгдчихөж байгаа байхгүй юу.

Энэ дээр Дээд шүүх маш ойлгомжтой хоёр удаа тайлбар хийчихсэн юм билээ. Энэ бол шүүхийн асуудал биш ээ гээд. Цэц эхний удаадаа бас Шүүхийн асуудал биш ээ гээд шийдчихсэн юм билээ. Тэгсэн хоёр дахь дээрээ харьяалал тогтоогоод өгчихсөн юм билээ. Харьяалал тогтоогоод өгөхдөө яасан гэхээр цэц бол манай хууль дээр харьяаллын тухай ийм нэг заалт байна. 1994 оноос. Гэхдээ бусад Үндсэн хуулийн шүүхэд огт байдаггүй чиг үүрэг. Монголд яагаад биччихсэн юм. Мэдэхгүй.

Монгол Улсын Үндсэн хууль дээр энэ чиг үүрэг Үндсэн хуулийн цэцэд огт өгөөгүй. Ийм чиг үүрэг байна. Тэгээд энэ чиг үүргийнх нь дагуу бид тэр үедээ тийм шийдвэр гаргачхаж гээд. Тэгэхдээ одоо яагаад цэц рүү ийм хүсэлт явуулж байгаа юм бэ гэдэг нюанс нь юу вэ гэхээр тэр шийдвэр чинь хууль хүчин төгөлдөр биш болгоод өөрчилсөн ч гэсэн хүчин төгөлдөр байхгүй юу. Тэр шийдвэрийг хэн зогсоох вэ гэхээр цэц өөрөө л зогсооно. Шүүх ямар тайлбарласан гэхээр цэц ингээд өгчихсөн учраас бид заавал шийдэх ёстой гээд цэцийг барьчихаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр замын зураг нь цэц рүү ямар нэгэн байдлаар энэ зүйл, заалтыг нь өөр лүү нь өгүүлээд, тэгээд Үндсэн хуулийнхаа үзэл санааны хувьд, Үндсэн хуулийнхаа дэг журмын хувьд нэг зөв шийдэл дээр аваачаад, тэгээд цэц шийдвэрээ тэнд засах тухай ярьж байгаа юм. Хөндлөнгөөс өөр хэн ч засах боломжгүй. Тэрийг.

Хуулийг өөрчлөх эрх бидэнд байгаа. Тэрийг маш сайн ойлгож байгаа. Хууль санаачлаад л хийчихнэ. Одоо бодитойгоор тэнд нэг тийм кэйс явж байгаа учраас тэр кэйсийг Үндсэн хуулийн суурь үзэл санаа, дэг журамтай нь уялдуулж засах арга зам л ердөө энэ. Энэ арга замаар л явъя гэдэг хувилбар. Өөр юм байхгүй.

Өнөөдөр одоо юу гэдэг юм одоо хэн нэгэн томилогдох юм, тэр тухай ерөөсөө яриа ерөөсөө биш. Одоо Улсын Их Хурал дээр хэлэлцэгдэж байгаа санал хураалттай өөр олон зүйлүүд ингээд шүүх рүү Улсын Их Хурал гаргаж өгөхөөр өөрөө Үндсэн хууль зөрчих гээд байгаа байхгүй юу. Үндсэн хуулийн бус үйлдэл болох гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийг зогцоох, үүнийг засах арга замын тухай л бид ярилцаж байгаа юм. Магадгүй иймэрхүү кэйс, иймэрхүү үйл явдлууд зөндөө л болох байх.

Д.Цогтбаатар: 1 минут нэмж өгье.

Х.Тэмүүжин: Одоо ингээд Улсын Их Хурлаас шүүхэд итгэмжилсэн төлөөлөгч томил энэ тэр гэдэг юм гарч ирж байгаа байхгүй юу. Захиргааны шүүхэд Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч томилж ерөөсөө болохгүй. Жишээ нь, ингээд яг шүүх одоо хууль дээр байж байгаа юмаараа л юмаа нэхэж эхэлж байгаа юм. Хугацаа өгөөд.

Үгүй. Болохгүй. Үндсэн хуулийн цэцийн шийдвэртэй шүү дээ. Болохгүй. Цэцээ шилжүүлчихсэн. Тэр шүүгч чинь эхлээд энэ шүүхийн асуудал биш байна гээд хоёр, гурван удаа анхан шатны шүүх нь шийдвэр гаргачихсан. Давж заалдах шатны шүүх нь хүчингүй болгоод үүнийгээ заавал шийд. Яасан цэцийн шийдвэртэй гээд өгчихсөн. Энэ чинь өөрөө тийм нэг хууль тогтоох тэнд нэг жижигхэн алдаа байна. Тийм ээ. Тэгээд.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ингэе. Тийм. Ер нь ийм байгаа шүү. Энэ асуудлын нэг онцлог нь Б.Энхбаяр гишүүн ээ, саяын таны ярьснаар байна шүү дээ. Одоо энэ анхан шатны шүүх, захиргааны шүүх үүнийг аваад хэлэлцээд бид нарыг дуудаж барихгүйгээр өөрөө тэндээ шийдвэр гаргах эрхтэй гэж байна шүү дээ. Та.

Өөрөө шийдвэр гаргаа л бол Улсын Их Хурал бидний гаргасан шийдвэр дээр энэ юрисдикцтэй байна гэдгийг бид хүлээн зөвшөөрчхөж байгаа байхгүй юу.

Дараагийн өөр шүүгч тэгж гаргахгүй бол яана. Тэгээд яг үүн шиг нотлох баримт нэхээд суувал дараагийн өөр дээр нэгэнт энэ дээр нь эсэргүүцэлгүй хүлээгээд авчихсан хүмүүс чинь нөгөө STAPLE гэдэг зарчим чинь шууд үйлчлэх боломжтой.

Тэгэхээр ингэе. Ойлголоо. Тэгэхээр ийм санал байна. Х.Тэмүүжин гишүүн ээ. Энд хоног хугацаанд бас амжиж бид хийхээр байгаа учраас түрүүн нэг асуудлыг хойшлуулчихлаа шүү дээ. Түүн шиг дараагийн долоо хоног руу хойшлуулаад.

Гишүүд ээ, үүнийгээ тэгвэл сайн судлаад. Энэ бол жинхэнээсээ судалъя гээд гишүүдийн хэлээд байгаа нь үнэн үнэн. Тал талаасаа хараад.

Яагаад гэвэл энэ чинь Үндсэн хуулийн асуудал гарч ирж байна. Хамгийн миний санаа зовж байгаа энэ асуудлын ноцтой үр дагавар юу гэхээр Их Хурал хуулийн өмнө хариуцлага хүлээдэг. Тэр нь яаж хүлээдэг хэлбэртэй вэ гэхээр гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг оновчгүй байх юм бол дараагийн сонгууль дээр очиж буруу шийдвэр гаргасан нөхдүүд, өөрөөр хэлбэл нам нь ч сонгогдохгүйгээр л хариуцлага хүлээдгээс шүүхийн өмнө очиж Их Хурлын гаргасан хамтын энэ шийдвэрээр хариуцлага хүлээдэг болох юм бол. Жишээлбэл, ажлаас нь буулгаж байгаа сайд нар шүүхдээд явах юм бол дуудагдах нь байна шүү дээ. Энэ чинь тэгэхээр үнэхээр зарчмын хувьд дараа дараагийн асуудал нь ноцтой байж болзошгүй.

Тэгэхээр бид бүгдээрээ тал талаас нь яг өнцгөө харж чадаж байна уу, үгүй юу. Энэ үүднээсээ нэг долоо хоног би энэ асуудлыг хойшлуулъя. Уг нь одоо дэмжээд санал гаргая гэдгийг нь л дэмжих гэж байгаа ийм томъёололтой юу орж ирж байгаа юм.

Х.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье. Үүнийг миний асуулт байлаа гэж үзээд Х.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Ер нь Үндсэн хуулийн цэцэд Улсын Их Хурал санал хүргүүлэх бүрэн эрхтэй. Үүнийгээ хэрэгжүүлсэн тохиолдол угаасаа байхгүй юм билээ. Тэгээд анхны удаагийнх болж байгаа юм. Нэг.

Хоёрт нь, саяынх шиг Дээд шүүхийн эрх мэдэл байсан байна. Энэ анхан шатын шүүхийн эрх мэдэл, шүүгч тэндээ тэгээд шийдэх ёстой байсан байна. Тийм. Үнэн. Үнэхээр Үндсэн хуулийн дэг журам тогтчихсон, шүүхийн практик, соёл нь хэлбэршчихсэн, хууль тогтоох эрх мэдлийг ердийн шүүх авч хэлэлцдэггүй гэдэг энэ үзэл санаа маш тодорхой байдаг улс оронд энэ үнэн байхгүй юу. Гэтэл манай дээр бодит байдал дээр юу болсон гэхээр энэ кэйс чинь үүсээд байна. Нэг.

Хоёрт нь, дахиад Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргачихсан. Одоо шүүгч нь юу ярьж байна гэхээр цэцийн тэр шийдвэрийг үндэслэж юмаа ярьж эхэлж байна. Цэцийн ийм шийдвэртэй учраас бид одоо асуудлыг заавал шийднэ гэж. Асуудлыг шийдэхийн тулд нөгөө процессын хуулиараа нотлох баримтууд нэхэж эхэлж байна. Шүүх өөрөө ажиллана шүү дээ, угаасаа. Нотлох баримтыг нэхэж эхэлнэ. Нотлох баримтыг нь өгөөд л эхлэх юм бол бид өөрсдөө Үндсэн хууль зөрчхөөд эхэлнэ. Бид өөрөө Үндсэн хуулийн байгууллага хамжилцаж нураалцана гэсэн үг.

Тэгэхээр бид нотлох баримтаа өгөхгүй байж болно. Чих нь дүлий байж болно. Тэгэнгүүт дахиад юу үүсэх вэ гэхээр нөгөө шүүгч чинь шүүгчийн

захирамж биелүүлэхийн тулд гээд дахиад араас чинь аягүй утга муутай зөндөө маргаанууд үүсэж эхэлж байгаа байхгүй юу. Үйл явдлууд үүсэж эхэлж байгаа.

Тэгэхээр энэ үйл явдлуудыг зогсоох ганц л арга байгаа. Тэр арга нь юу вэ гэхээр Үндсэн хуулийн цэц шийдвэрээ эргэж харах. Шийдвэрээ эргэж харахдаа Үндсэн хуулийн цэц юу гэж хэлж байна гэхээр Улсын Их Хурал манайх руу саналаа явуул гэж хэлж байгаа.

Тэгэхээр бидэнд байгаа эрх мэдэл, бидэнд байгаа нөөц нь энэ. Шүүхийг та нар ингэж шийдвэр гаргаж хөндлөнгөөс нь заах ямар ч боломж байхгүй.

Д.Цогтбаатар: Х.Тэмүүжин гишүүн ээ, би нэг юм тодруулаад асуучихъя.

Одоо ингээд бид нээрээ энэ бас гишүүдийн болгоомжлоод байгаа нь зөв. Хэдүүлээ санал гаргаад явууллаа. Тэгээд Үндсэн хуулийн цэцэд үүнийгээ эргээд харах боломж байна уу гэсэн. Үндсэн хуулийн цэц бид зөв шийдвэр гаргажээ гээд явчихвал яах вэ?

Тэгэхээр ингэе. Энэ асуудлыг дараагийн Байнгын хорооны хурал хүртэл хойшлуулъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Долоо хоногоор хойшлуулж байна. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

Үүнийг ингэж хойшлуулж байгаа нь 14 хоногийн дотор бид санал, дүгнэлт оруулах бүр ийм цаг хугацаатай, цаглавартай асуудал учраас эндээ багтаад амжаад явъя.

Ингээд дараагийн асуудалдаа орёё.

**Найм.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн
Монгол Улсын ерөнхий прокурорын албан тушаалд томилох саналыг
зөвшилцөх тухай асуудал**

Наймдугаар асуудал. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Монгол Улсын Ерөнхий прокурорыг томилох асуудлыг зөвшилцөх тухай.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 17, Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Банзрагчийн Жаргалсайханыг Монгол Улсын Ерөнхий прокурорын албан тушаалд томилох асуудлыг зөвшилцөхөөр Улсын Их Хуралд ирүүлсэнийг хэлэлцье.

Монгол Улсын Ерөнхий прокурорын албан тушаалд нэр дэвшигч Банзрагчийн Жаргалсайханы танилцуулгыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Гомбожавын Занданшатар дарга танилцуулна.

Ажлын хэсэг байрандаа суугаарай. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан албан тушаалтнуудыг эхлээд танилцуулчихъя.

Монгол Улсын Ерөнхий прокурор, Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх Б.Жаргалсайхан, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна.

Г.Занданшатар даргын микрофоныг өгье. Одоо нэр дэвшигчийн танилцуулгыг хийнэ. 2 дугаар микрофон.

Г.Занданшатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Үндсэн хуулийн 56.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 17, Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийг үндэслэн Банзрагчийн Жаргалсайханыг Монгол Улсын Ерөнхий прокуророор улируулан томилох асуудлыг Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр танилцуулж байна.

Бадарчийн Жаргалсайхан 1964 онд Өвөрхангай аймгийн Хайрхандулаан суманд төрсөн. Ам бүл 4 эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг.

Боловсрол 1973-1983 онд Өвөрхангай аймгийн 2 дугаар 10 жилийн дунд сургуулийг төгссөн.

1983-1988 онд Монгол Улсын Их Сургуулийн Нийгмийн ухааны факультетын хуулийн салбарыг хуульч мэргэжлээр төгссөн.

Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх зэрэг дэвтэй.

Б.Жаргалсайхан прокурорын байгууллагад нийтдээ 37 жил ажилласан.

1988-1996 онд Өвөрхангай аймгийн прокурорын газарт Хэсгийн прокурор, Хяналтын прокурор, Туслах прокурор, Орлогч прокурор;

1996-2000 онд Өвөрхангай аймгийн прокурор;

2000-2001 онд Улсын ерөнхий прокурын газарт Хяналтын прокурор;

2001- 2009 онд Тээврийн прокурор;

2009-12011 онд Улсын ерөнхий прокурын газарт Хэрэг эрхлэх газрын дарга;

2011-2014 онд Тээврийн прокурор;

2014-2016 онд Улсын ерөнхий прокурын газарт Дотоод аюулгүй байдлын хэлтсийн дарга;

2016-2017 онд Улсын ерөнхий прокурын газарт Тамгын газрын орлогч дарга;

2017-гоос 2019 онд Улсын ерөнхий прокурын газарт Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга;

2019 оноос Монгол Улсын Ерөнхий прокуророор ажиллаж байна.

Прокурорын тухай хуулийн 45.4, 46.1 дэх заалтад тавьсан тусгай шаардлагууд болох хуульч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, 35-аас дээш насны прокуророор ажиллаж байгаа хүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралтай зөвшилцөж томилно гэсэн тусгай шаардлагыг хангасан тул, ийм учраас Банзрагчийн Жаргалсайханыг Монгол Улсын Ерөнхий прокурор томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Г.Занданшатар даргад баярлалаа.

Ингээд Ерөнхийлөгчөөс ирүүлсэн нэр дэвшигчийн танилцуулгыг Та бүгдэд тараасан байгаа.

Нэр дэвшигчийн танилцуулга болон нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү.

Ц.Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Х.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Би Ерөнхий прокурор нэр дэвшиж байгаа хүнтэй ярих юм алга.

Урд, хойдох юу хийх энэ тэр гээд олон зүйлийг асууж болох байх. Би хоёр л юм асуухыг хүсэж байгаа юм.

Нэгдүгээрт нь, ер нь бид хуулийн засаглал бүхий улс орон руу шилжихийн тулд хүссэн хүсээгүй Үндсэн хуулийн байгууллагаараа хоёр юмыг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болно.

Тэр нь юу вэ гэхээр эрх мэдэл хуваарилж байгаа Үндсэн хуулийн байгууллагын гол зарчим гүйцэтгэх эрх мэдлийг нэг талаасаа “шүүхийн хяналтад оруулах”, нөгөө талаасаа “парламентын хяналтад оруулах” л том зорилготой.

Шүүхийн хяналтад оруулна гэдэг нь шүүгч нар бүх юмыг шийдэх гэсэн үг биш. Шүүн таслах үйл ажиллагаа буюу тэр хэлэлцүүлэг, HEARING_[шүүх хуралдаан]-д эрх мэдлийг шилжүүлнэ гэсэн үг болно.

Хэрвээ бид HEARING-гийг ач холбогдолтой гээд дэмжвэл одоо прокурор дээр байж байгаа зөвшөөрлийн тогтолцоог бүхэлд нь шүүх рүү өгөхөөс өөр арга байхгүй. Шүүхийн өмнө прокурор, өмгөөлөгч яагаад энэ процессын арга хэмжээг авах хэрэгтэй, яагаад энэ нотлох баримт болж байгаа юм, яагаад энэ хүн буруутай, буруугүй вэ гэдэг асуудлаа мэтгэлцэж шүүхийн өмнө эрх тэгш байдлаар хангадаг тэр зарчим руугаа явна гэсэн үг.

Ийм том концепцын шинэтгэлийг дэмжих үү, дэмжихгүй юу гэдэг асуултыг нэр дэвшигчээс асууж байгаа юм.

Хоёрт нь, би Г.Занданшатар даргаас асуумаар байна.

Прокурорын тухай хууль, Төрийн албаны тухай хууль хоёр дээр чинь зөрчил үүсэж байна. Энэ зөрчил үүсэж байгаа хуулийнхаа нюансыг та яаж тайлбарлах юм бэ гэдэг асуултыг асуумаар байна.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороон дээр орж ирж байгаа гол шалтгаан нэгдүгээрт энэ салбарын хүн.

Хоёрдугаарт, хуулийн дагуу томилогдож байгаа юу гэдэг л хоёр асуултын л хариу байгаа. Энэ асуулт дээр хариу авчихъя.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Б.Жаргалсайхан: Эрхэм гишүүдийн энэ оройн амгаланг айлтгая. Гишүүний асуултад хариулъя.

Одоо үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд шүүхээр зөвшөөрөл өгдөг, шүүхийн зөвшөөрлөөр явдаг олон зүйлүүд өөрчлөгдөж орж ирсэн.

Хүний эрх талаасаа энэ бол маш чухал заалтууд. Гишүүний ярьж байгаа энэ зүйл дээр би дэмжсэн байр суурьтай байгаа юм. Учир юу вэ гэвэл хүний эрхтэй холбоотой энэ асуудал болгон шүүхээр хэлэлцдэг.

Гэхдээ дэмжсэн байр суурь дээр нэг асуудал бий. Манай тогтолцооны өөрчлөлт юу билээ. Ром, Герман, Англи-Саксон.

Тэгэхээр энэ зүйл дээр зарим нэгэн зүйл дээр мэтгэлцэх зарчим үйлчилнэ, зарим дээр нь мэтгэлцэхгүй асуудлууд үүсдэг. Тэгээд энэ нөхцөл байдлуудыг уян хатан хууль тогтоогч шийдээд явах юм бол энэ дээр прокурорын байгууллагын зүгээс дэмжихгүй гэх. Прокурорын байгууллага өөрөө хууль хэрэгжүүлэгч байгууллага. Парламентаас батлагдсан хуулийг хэрэгжүүлээд л явна. Хариулт ийм байна. Хариулж дууслаа.

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон.

Г.Занданшатар: Х.Тэмүүжин гишүүн чухал хуулийн зөрчилтэй байж болзошгүй асуудлын талаар тодрууллаа.

Энэ асуултад Хууль зүйн байнгын хороо тодорхой хариулт өгсөн гэж бодож байна.

Прокурорын тухай хуульд Прокурорын тухай хуулийн 60.3-д заасан нийтлэг прокурорт тавих шаардлагаас тусдаа Ерөнхий прокурорт тавих шаардлагыг 45.4-д хуульч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, 35 насанд хүрсэн прокурорыг, прокуророор ажиллаж байгаа хүнийг Улсын Ерөнхий прокурор, түүний орлогчоор томилно гэж заасан.

Ингээд Улсын Ерөнхий прокурорыг Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралтай зөвшилцөн 6 жилээр томилно гэж тусдаа зохицуулалтаар зохицуулсан. Нэг.

Хоёрдугаарт нь, төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөж, прокурорын асуудлыг хэрэгжүүлнэ гэж 68.1-д заасан. 60.3 дахь зөрчилдөж байгаа биш.

Төрийн албаны тухай хууль 2018 онд Прокурорын хуулийн дараа батлагдсан нийтлэг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон гүйцээгээд хариулъя.

Г.Занданшатар: Тийм учраас сүүлд батлагдсан Төрийн албаны нийтлэг хуулиа урьж байгаа юм.

Гуравдугаарт, саяхан Үндсэн хуулийн цэцийн шүүгчийн настай холбоотой заалтыг Улсын Их Хурлын чуулганаар болон Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцэхдээ энэ асуудлын зөрчлийг нэг мөр тэмдэглэж, Хууль зүйн байнгын хорооны дарга болон гишүүд хуулийн байгууллагууд дээр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг нэг мөр шийдвэрлэж авъя гэж тэмдэглэсэн нь энэ хуулийн зөрчлийн асуудлыг бас тодорхой болгосон гэж үзэж байна.

Цаашдаа хууль эрх зүйн зохицуулалтуудыг улам боловсронгуй болгох шаардлага байгаа.

Ер нь дэлхий нийтийн жишгийг бас харгалзан үзэх нь шаардлагатай байх гэж бодож байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Д.Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Ингээд ер нь Ерөнхий прокурорыг 6 жилээр сунгаж томилдог. 6 жилээр томилдог албан тушаал цөөхөн бий.

Ингээд 6 жилээр ажиллуулах, ажиллах баталгаа ямар байгаа вэ? Тавьчхаад нэг их удахгүй хоёр, гурван жил болоод солих гээд л эхэлдэг. Тийм ээ. Ийм тал байх уу, үгүй юу гэж Ерөнхийлөгчийн Тамгын газраас асуух нь зөв байх. Үүнийг тодруулъя.

Нөгөө талаар бид улс төрчдөөр Ерөнхий прокурорыг тавьж байсан. Түүний үр дагавар нь ямар байсныг бүгдээрээ мэднэ л дээ. Янз бүрийн хонгилд автдаг, хонгил үүслээ энэ тэр гээд байсан.

Сүүлийн үед мэргэжлийн хүнээр, энэ прокурорт 40-өөд жил шахуу ажилласан, 30 гаран жил ажилласан хүнээр томилж үзэж байна. 6 жил энэ прокурорын байгууллага нэлээн хуулийн дагуу, боломжийн дагуу ажиллаж байгаа гэж ойлгож байгаа. Цаашдаа ч сайжрах байх гэсэн ийм хүлээлт байна.

Гэхдээ өнөөдөр ер нь өнгөрсөн энэ юмнуудыг хараад байхад шүүх дээрээ хэргүүд очиж байна. Миний мэдэхийн 40 саяын торгууль аваад л гараад байдаг байсан болчихлоо. Тэгсэн чинь өнөөдөр л гэхэд одоо энэ “ногоон автобус” ямар ч ялгүй гарч байна. Үүний цаана чинь баахан л хохирол байгаа л даа.

Шүүхийн үйл ажиллагаа мэдээж хэрэг гурван шаттай. Тэр нь дуусаагүй байгаа байх. Прокурор хууль сахиулахыг, хэн нэгэн хүн ял завшихыг. Энэ талаас нь ханддаг байх.

Нөгөө талаар Та бүхэн бас ял эдлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Тийм тусдаа ч прокурор байгаа байх. Тэрийг хариуцсан.

Гэтэл энэ ял эдэлж байгаа юм чинь юу болж байна. Зүгээр ял авчихсан хүн чинь хэдэн тэрбум, 7, 8, 9 тэрбумыг завшсан, луйвардсан ийм хүн шүүхээс ял шийтгэл аваад явдаг. Гэтэл галч хийгээд байж байсан байна шүү дээ. Амралтын газар. Энэ одоо яагаад ийм байна вэ? Үүнийг хэн хариуцах ёстой юм гэсэн ийм асуудлууд байна л даа.

Д.Цогтбаатар: Эхний асуулт 2 дугаар микрофон хариулъя.

Г.Занданшатар: Д.Ганбат гишүүний асуултад сүүлээс нь эхлээд хариульъя гэж бодож байна.

Улс төрчийг томилсон гашуун сургамж дээр дүгнэлт хийгээд Улсын Их Хурлаас хууль баталж, прокурорыг томилно гэсэн заалт саяын Прокурорын тухай хуулийн 45.4-д заасан хуульч мэргэжлээр 10-аас дээш ажилласан, 35 нас хүрсэн прокурорыг, прокурорын байгууллагад ажиллаж байгаа хүнийг прокурорыг томилно гэж заасан нь улс төрч томилох прокурорын байгууллагыг улс төржүүлжүүлэх асуудлыг хаасан ийм зохицуулалт хийснээр одоо ингээд прокурорыг томилдог ийм жишиг тогтоод хэрэгжээд явж байна.

Прокурорын албан тушаалаас “чөлөөлөх”, “халах”, “бие даасан байдлыг хангах” асуудал тусдаа хуулиар зохицуулагддаг.

68 дугаар зүйлд Улсын Ерөнхий прокурор төрийн албаны хуульд зааснаас гадна дараах үндэслэлээр прокурорыг албан тушаалаас нь чөлөөлнө. Өөрөөр хэлбэл өөрийнх нь зөвшөөрснөөр. Биеийн эрүүл мэндийн байдлын улмаас үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон бол. Энэ хууль болон бусад хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн бол гэдэг нь Төрийн албаны хуулиа барина гэсэн агуулга.

68.1.4 нь мэргэжлийн болон ажил хэргийн ур чадварын хувьд эрхэлсэн ажилдаа тэнцэхгүй тухай мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гарсан, Төрийн албаны хууль энэ хуульд заасан үндэслэлээр прокурорыг албан тушаалаас чөлөөлнө гэж, улс төрийн болон бусад шалтгаанаар прокурорыг халах, чөлөөлөх асуудлыг хуульчилж хааж өгсөн.

Тэгэхээр энэ хуулийнхаа дагуу л прокурорын бие даасан, тогтвортой ажиллах бололцоо хангагдаж байгаа.

Ийм ч учраас 2019 онд өмнөх Ерөнхийлөгчийн үед томилогдсон прокурорыг хуулийг дээдэлж, зарчимтай, нуруутай ажиллаж байна гэсэн үндэслэлээр Ерөнхийлөгч дахин нэр дэвшүүлж өнөөдөр Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр танилцуулж байна.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон өгье.

Б.Жаргалсайхан: Д.Ганбат гишүүний асуултад хариульъя.

Миний хувьд ойлгож байгаагаар 2 хэргийн асуудал яригдаж байна гэж ойлголоо.

Нэг дэх нь, “Ногоон автобусны хэрэг”. Энэ нийгэмд нэлээн дуулиан тарьсан олон хэргүүдийн нэг нь энэ ногоон автобусны хэрэг. Энэ хэрэг дээр надад авч байгаа, одоо нийтэд ил болсон мэдээллээр бол прокурор өөрийнхөө

шүүхэд шилжүүлсэн зүйл, хэсгүүдээр ялсан. Шүүх цагаатгасан гэсэн ийм мэдээлэл өнөөдөр бас орж ирж байна. Намайг энд байж байх үед.

Тэгэхээр шүүх цагаатгана гэдэг нь шүүх өөрсдийнхөө дотоод итгэлээр л энэ асуудлаа шийдэж байгаа. Прокурор өөрийнхөө дотоод итгэлээр энэ хэргийг гэм буруутай гэж шүүхэд шилжүүлсэн. Яллах дүгнэлт үйлдэж.

Тийм учраас дараа дараагийн шатны шүүхийн үйл ажиллагаа нь шүүх хуралд оролцсон прокурорын үйл ажиллагаанаас хамаарна.

С.Батдөл гэж нийт тодорхой болсон хүний талаар л та тодорхой асууж байх шиг байна.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон өгье. Гүйцээж хариулъя.

Б.Жаргалсайхан: Прокурорын байгууллага ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьдаг.

Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавихын зэрэгцээ нээлттэй, хаалттай хорих ангиуд дээр тодорхой ял эдэлж байгаа хүмүүст ажиллах, харуул хамгаалалттай ажиллах зөвшөөрлийг олгодог.

Тухайн хүний хувьд нэг сарын хугацаанд одоо тэр заагдсан газар ажиллаж байсан. Прокурор энэ шаардлага хангахгүй байна гэж анги байрлалыг нь сольсон ийм мэдээлэлтэй байгаа. Хариулж дууслаа.

Д.Цогтбаатар: Д.Ганбат гишүүний микрофоныг өгье. Тодруулъя.

Д.Ганбат: Яах вэ ерөнхий нийтэд л байгаа юмыг тодруулж л байна л даа. Түүнээс биш прокурорын үйл ажиллагаа юм уу, шүүхийн дуусаагүй үйл ажиллагаа ямар нэгэн байдлаар нөлөөлөх гэсэн бодол байхгүй ээ.

Гэхдээ бас шударга ёсны зарчим ажиллаж байх ёстой шүү гэдгийг анхааруулах гээд байгаа юм. Ажлаа бүгд хийх ёстой.

Нөгөө талаар би ахиад тодруулъя. Яг 6 жилээр бид сунгах ёстой, томилох ёстой. Прокурорыг. Энэ 6 жилээрээ ажиллах уу? Ажиллуулах ч ёстой. Хэрвээ томилчихсон бол. Энэ дээр зөвшилцөх гээд оруулж ирсэн Ерөнхийлөгчийн институцээс ахиж тодруулъя. Тийм.

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон. Г.Занданшатар даргын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Прокурорын тухай хуулиараа 6 жилээр томилж, чөлөөлөхөөр заасан.

Чөлөөлөх тодорхой үндэслэлүүдийг 68 дугаар зүйлд заасныг би бас сая тодорхой уншиж танилцууллаа. Өөр үндэслэлээр чөлөөлөх, халах боломжгүй. Ийм учраас 6 жилээр тогтвортой ажиллуулахын тулд, энэ хуулийн байгууллага, систем тогтвортой ажиллахын тулд дахин нэр дэвшүүлж өнөөдөр Улсын Их Хуралд зөвшилцөж танилцуулж байгаа.

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Би хоёр зүйлийг асууя.

Нэгд, тэр дундаа гэмт хэрэг, эрүүгийн хэрэг дээр авлига, албан тушаалын гэмт хэрэг, авлигын гэмт хэрэгтэй холбоотой төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой хэргээс гол нь тоо баримт асууж байгаа юм шүү.

Танай прокурорын шатад хэрэг буцаагддаг. Нөгөө талаар шүүхийн шатад хэрэг буцаагдаж хэрэгсэхгүй болдог.

Танайхаас яллах дүгнэлт үйлдүүлээд явсан авлигын гэмт хэрэгт хэдэн хувь нь шүүхээр очиж шийдэгдэж байна, хэдэн хувь нь хэрэгсэхгүй болж буцаагдаж байна вэ?

Эндээс юу харагдах вэ гэхээр прокурорын шатад прокуроруудын хяналт тавьсан байдал, хуулийн хүрээнд ажлын ур чадвар, асуудалд хандаж байгаа хандлага, байдал юмнууд бас харагдах болов уу гэж. Энэ тоо судалгаанаас. Энэ дээр одоо танд ямар тоо баримт байна вэ? Нэгд.

Хоёрт, би таны өмнөх прокурор М.Энх-Амгалан гэж прокурор байсан. Тийм ээ. Би хоёр, гурван удаа тэр прокурорын хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч байсан зүйлийг үнэхээр харж бахархаж байсан.

Монгол төрийн Монгол хууль сахиулах байгууллагуудын өндөр албан тушаалтнууд ингэж асуудалд ханддаг бол бас болж байна гэж. Хууль, шүүх, прокурорын байгууллагад итгэх итгэл тэр зэргээр нэмэгдэж байсан. Тухайлбал, танай өмнөх прокурор энэ “Төрийн ордон дотроос, энэ чуулганы танхимаас хариуцлага эхлэх ёстой” гэдэг үг үнэхээр байгаа оносон үгийг хэлж байсан. Асуудалд тэгж хандаж байсан.

Хоёрт, Х.Баттулга Ерөнхийлөгч байхдаа Ц.Элбэгдоржийн талаар шалгуулах материалыг прокуроруудыг бүрэн бүрэлдэхүүнээр нь суулгаж байгаад өгч байсан. Шалгаж өг гэдэг асуудлыг. Тэгэхэд “үгүй ээ, ийм юм байдаггүй юм” гэдэг юмыг ярьж бас асуудалд хандаж байсан. Энэ хоёрхон жишээнээс харахад үнэхээр төрийн хууль цаазын хүмүүс асуудалд ингэж хандаж байх ёстой юм байна гэдэг байдлыг харуулж байсан.

Тантай ийм асуудал Таны өнгөрсөн бүрэн эрхийн хугацаанд гарч байсан уу? Хөндлөнгийн байдлаас нөлөөлөх байдал гарч байсан уу? Хэрвээ гарч

байсан бол энэ асуудалд яаж хандаж байсан бэ? Цаашдаа ийм асуудал гарахгүй гэх баталгаа байхгүй. Хэрвээ ийм асуудал гарвал та асуудалд хэр шударгаар Монголын ард түмний хууль шүүхийн талд асуудалд хандаж, шударгаар хандаж чадах уу, үгүй юу? Энэ дээр та хариулт өгөөч.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Б.Жаргалсайхан: Прокурорын хувьд прокурор “төрийн тусгай албан хаагч”.

Прокурор өөрөө өргөсөн тангарагтай.

Тийм учраас өргөсөн тангаргаасаа няцахгүй ажиллах үүрэгтэй юм. Манай бүх прокурорууд энэ өргөсөн тангарагтаа үнэнчээр ажиллаж байгаа гэж би боддог. Ажилласаар ч байгаа.

Миний хувьд ямар нэгэн нөлөөлөл байгаагүй. Ер нь зүгээр ерөнхий байдал ингээд харахад “хэргийн нөлөөлөл”, “томилгооны нөлөөлөл” гэдэг ийм л хоёр нөлөөлөл байдаг л даа. Аль ч газар.

Ямар ч томилгооны нөлөөлөл байгаагүй, ямар ч хэргийн нөлөөлөл байгаагүй.

Энэ бол прокурорын байгууллагын өөрөө бие дааж ажиллах энэ гол суурь нь юм. Тийм ч учраас 2019 онд та авлигалтай холбоотой хэрэгтэй хэргийг асууж байна. 78 хэрэг шүүхэд шилжиж байсан. 2019 онд. Өнөөдөр шүүхэд 306 хэрэг 2004 оны байдлаар шилжсэн. Энэ бол прокурор өөрөө бие даасан хэргийг шилжүүлж, өөрийнхөө үндсэн үүргээ хэрэгжүүлж байна л гэсэн үг.

Авлига, албан тушаалын хэрэгтэй холбоотой хэд хэдэн тоо баримт бий.

- ▶ 2022 онд 188,
- ▶ 2023 онд 93,
- ▶ 2004 онд 222.

Одоо энэ 2025 оны 1 сарын байдлаар 64 хэрэг.

Ингээд нийтдээ 667 авлига, албан тушаалын хэрэг шилжсэн байна.

Тэгэхээр ингээд харахад прокурорын байгууллага өөрөө бие даасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаж байгааг энэ тоо баримтаар илэрхийлэгдэх юм гэж таны асуултад хариулж байна.

Д.Цогтбаатар: Тодруулах уу? Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Одоогоос 3 жилийн өмнө байх аа. 2-оос 3 жилийн өмнө прокуроруудын оролцсон гэх бас олон нийтийн сүлжээгээр гарсан асуудлууд

гарсан. Янз бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр. Хүүхэн шуухантай холбоотой асуудал гарч байсан. Өөр бас янз бүрийн асуудалтай холбоотой, нэр бүхий прокуроруудтай холбоотой асуудал.

Энэ хэрэг одоо юу болж таарч таарсан бэ? Дууссан бэ? Манайхан болохоор одоо ингээд л нэг хэрэг гарахаар нь нэг гараад л нэг бөөн дуулиан шуугиан болоод л ингэж явдаг. Тэгээд л замхарсаар замхарсаар ерөөсөө өнөөдөр усанд хаясан чулуу шиг хэрхэн яаж шийдэгдсэн нь мэдэгдэхгүй ингээд л өнгөрдөг.

Тухайн үеийн хэрэгт холбогдож байсан прокуроруудын асуудлууд өнөөдөр яаж шийдэгдсэн бэ? Прокуроруудын өөрсдийнх нь холбогдсон асуудлууд. Энэ дээр нэг хариулт өгөөч.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Б.Жаргалсайхан: Хэрэг нь чухам ямар хэрэг юм бол доо. Ямар ч байсан ер нь прокурортой холбоотой 8 холбогдолтой зөрчил гаргасан прокуроруудыг ажлаас чөлөөлсөн.

Би бодохдоо тэр дотор байгаа хүн чөлөөлөгдсөн. Нэрийг нь хэлээгүй боловч тэр хүн одоо шүүхээр үндэслэлгүй чөлөөлсөн гээд хүсэлтээ гаргаад явж байгаа нэг ийм л тохиолдол байна.

Би таны хэлж байгаа тэр хэргийг миний энэ хэлж байгаа хэргийг мөн байх л гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Н.Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Прокурорын байгууллага гэдэг чинь их чухал үүрэгтэй байгууллага юм байна лээ л дээ.

Ц.Элбэгдорж, Миеэгомбын Энхболд хоёрын үед Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, хууль хяналтын байгууллага гэж бид ярьдаг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурор, нэг нь юу билээ, Авлигатай тэмцэхийн дарга гурав. Тэр гурвыг өөрсдийн хүнээр тавьж аваад ёстой нэг алж өгсөн.

Дараагаар нь энэ Х.Баттулга Ерөнхийлөгч болоод, одоо Ерөнхийлөгч болсон У.Хүрэлсүх, нэг нь Г.Занданшатар. Энэ хамт сууж байна шүү дээ.

Энэ гурав одоо болохоо байлаа. Энэ өмнөх хүмүүс ер нь болохгүй байна. Эд нарыг нэг өөрчлөхгүй болбол энэ хонгил ер нь хэцүү юм байна гээд гурван хүн гаргаж ирж тавьсны нэг нь одоо энэ Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, АТГ-ын дарга З.Дашдаваа. Энэ хоёр хүнийг хоёуланг нь буцаагаад томилъё гээд оруулж ирж байгаа л юм байна л даа.

Хүнээс хамаардаг ч юм байна. Энэ улс төрчид гэж солиотой, галзуутай юмнуудаас хамаардаг юм чинь энд томилогдож байгаа хүмүүс их байгаа.

Би ер нь одоо энэ улс төрчид томилж байгаа цагт энэ улс төрийн нөлөөллөөс ангижрахгүй юм байна гэж ойлгож байгаа. Б.Жаргалсайхан гуайг болбол одоо гайгүй майгүй гээд л баахан л юм ярьцгааж байна лээ.

Би саяын энэ хэдэн жилийн хугацааг нь харахад тэр улс төрийн шинжтэй 80 хүний хэргийг багцалж оруулна гэдэг бол Монголын түүхэнд байхгүй шүү. Тэр Хөгжлийн банкны хэргийг би яриад байгаа юм.

Хөгжлийн банкны гэж хэрэг байж болно. Тэгээд л тэр хэрэг хэргээр нь ингээд ингээд ингээд ингээд салгаад ингэхгүй 3 сар гаруй 80 хүнийг Драмын театрт тоглуулаад, тэгээд 80 гаруй хүнээс 40-өөд нь билүү, цагаадаад ингээд явсан байхгүй юу. Тэгээд тэрний хойноос одоо ингээд л дахиад л өчнөөн хэдэн сар жилээр явуулж байдаг.

Тэгэхээр би одоо энэ үйлдлээс энэ улс төрчдийн нөлөөлөл бас л танаас салахгүй л байна даа хөөрхий л гэж бодож байгаа.

Ер нь манай Их Хурлынхан, манай энэ Байнгын хорооныхон прокурорын байгууллага дээр бид бас хамтраад шинэчлэл хийх ёстой байх. Энэ бол Б.Жаргалсайхан ерөнхий прокурорын ажил ч биш байх.

Энэ босоо тогтолцоо нь асар их одоо тийм сөрөг, Монголын нийгэмд маш их сөрөг авчирч байгаа юм. Даргын томилогдсон хүн бол даргадаа л үйлчилнэ. Түүнээс хууль биелүүлэх, хуульдаа үйлчлэх гэдэг юм бол зүгээр онолын хувьд л бид яриад байгаа болохоос байдаггүй юм шиг байна лээ. Ийм ийм юмаа өөрчилмөөр байна.

Тэр хорих газрууд дээр хүртэл магадлангаар гаргана гэдэг чинь л үзэмжээр л явж байна шүү дээ. Уг нь тэр ял эдлэх жилийнх нь хагасаар нь гаргачхаар юм байхад.

Одоо тэр Хөгжлийн банкны хэргээр орсон нэг залуу. Одоо нэрийн хэлдэг л байх даа. Н.Мөнхбатыг өчнөөн тамлаж байгаа шүү дээ. Энэ чинь 2 жил 8 сар авсан бол 1.4 жилээр ордог байхад зарим хүмүүсийг үзэмжээр нь 2 жил хүртэл явуулна.

Ийм ийм юм та нар л ажигладаггүй болохоос биш над шиг нөгөө хонгилоор нь яваад гараад өчнөөн олон залуучууд бас одоо ингээд хожим нь хэлмэгдэж байгааг харахад их харамсалтай байдаг шүү.

Д.Цогтбаатар: Н.Алтанхуяг гишүүний микрофоныг өгье. 1 минут.

Н.Алтанхуяг: Би сая бүлэг дээр асуучихсан юм. Би асуулт асуугаагүй. Ер нь зүгээр санал хэлчихье.

Бас таныг анхаарч ажиллаасай. Одоо ингээд баахан нөхдүүд танд хайр зарлаад л бүгдээрээ л дахиад 6 жил болго л гэж байна лээ. Үгүй ээ, тэгээд болго л доо. Тэгэхдээ жаахан юм хий л дээ. Хууль ёсыг нь сахиулаад өг л дөө.

Би танд бас түрүүн хэлсэн. Одоо дахиад хэлчихье. Энэ Б.Содномдаржаа, Т.Чимгээ нарыг хэрэгт төвөгт нь ингээд хэлмэгдүүлсэн хүн, эд нар нь цагаадчихаад байхад яагаад танай прокурорын байгууллага энэ хэргийг хариуцаж байсан Б.Батжаргал гээд прокурор нь Өмнөговийн Ерөнхий прокурор болоод явчихдаг юм бэ гэсэн. Та нэг хариулаад хэрэггүй байх.

Зүгээр ер нь ингээд бас ухаад яривал, үнэхээр Монголын нийгмийг жаахан шударга болгоё гээд яривал ярих юм зөндөө л байгаа. Тэгэхдээ та 6 жил ажилласан. Жижиг сажиг нөлөөлөл орсон байх. Мэдээж прокурорын бүх үйл ажиллагаанд улс төрчдийн нөлөөлөл юм уу, босоо нөлөөлөл байхгүй байх. 100 хувь гэж би хэлээгүй шүү. /минут дуусав/

Д.Цогтбаатар: П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Мэдээж Ерөнхий прокурор хуулиар олгогдсон бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд “хэрэг бүртгэх”, “мөрдөн байцаалт”, “ял эдлүүлэх” ажиллагаанд хяналт тавина. Түүнээсээ гадна прокурорын институцийг цаашдаа яаж илүү их ил тод нээлттэй, илүү их хуулийн дагуу хүлээсэн чиг үүргээ биелүүлэх, хэрэгжүүлэхэд нь хууль эрх зүйн талаас нь дэмжих үү, зохион байгуулалт талаас нь дэмжих үү гэдэг зүйл дээр Ерөнхий прокурор ажиллах ёстой байдаг.

Тийм учраас Ерөнхий прокуророор нэр дэвшиж байгаа танаас хоёр, гурван зүйлийг тодруулж асууя гэж бодож байна. Ер нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үүсэж байгаа хавтаст хэргийг цахимжуулах асуудал дээр Зөрчлийн хуулиас эхлээд бид ярилцаад хийгээд явж байсан. Энэ ажил ямар үе шаттай яваа вэ? Ер нь прокурорын байгууллага дахь цахимжилтын бодлогыг Та дэмжиж ажиллах уу гэдэг байр сууриа олон нийтэд хэлж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм.

Дараагийн миний нэг асуух зүйл энэ прокурорын хуулийг би 2017 онд боловсруулж батлуулсан хүн л дээ. Тэгээд мэдээж энэ хууль дээр эргээд харах зүйлүүд бас байгаад байна.

Энэ хууль хэрэгжээд 8 жил болчихлоо. Тэгээд ингээд харахаар Прокурорын ёс зүйн зөвлөлийг эргэж харъя. Шүүхийн сахилгын хороо гээд шүүгчдийн сахилга, ёс зүйн асуудлыг бие даасан сахилгын хороо бие даасан процесстой хэрэгжээд явж байхад Прокурорын ёс зүйн хорооны асуудал бас олон нийтэд шүүмжлэл дагуулдаг. Ялангуяа зөвхөн прокурорууд өөр өөрсдөө

бүрдүүлчихээр янз бүрийн одоо юу гэдэг юм, дарамт, шахалт, нөлөөлөл ордог юм биш биз дээ гэдэг зүйлийг Хуульчдын холбоо хавиас ерөнхийдөө ярьдаг.

Тийм учраас энэ асуудлыг зохистой байлгах, ил тод нээлттэй байлгах талаас нь би холбогдох хуулийн өөрчлөлтүүдийг хийхэд хамтарч ажиллая гэж бодож байгаа. Тэгээд энэ дээр ямар байр суурьтай байдаг вэ гэдэг зүйл байгаа.

Тэгээд ер нь хууль дээрээс прокурорын байгууллагын өнгө төрхийг өөрчлөөд энэ хувцас формыг ч гэсэн аваад хаячихмаар санагдаж байгаа.

Ер нь прокурорууд нэг их тийм дүрэмт хувцас өмсөөд л, янз бүрийн одоо тийм кительтэй хувцас өмсөөд байх ер нь шаардлага байхгүй юм шиг байгаа юм.

Тэгэхээр наад захын энэ зүйлээс эхлээд прокурорын хуулиудыг өөрчлөх, жижиг сажиг гэлтгүй хэмнэлттэй бөгөөд иргэдийнхээ төлөө, хуульт ёсны төлөө буюу энэ RULE OF LAW-г бэхжүүлэхийн төлөө явдаг институц гэдэг талаас нь харуулах тэр жижиг өөрчлөлтийг ч гэсэн хийчихмээр байна гэдэг зүйлийг танд хэлмээр байна.

Тэгээд прокурорыг мэргэшүүлэх асуудал дээр таны байр суурь ямар байдаг вэ? Одоо яах вэ, мэдээж прокурор дээр хяналт тавих, хэргүүдийн хуваарилалтын асуудлыг ерөнхийдөө дээд шатын прокурор хийгээд явж байгаа байх. Тэгэхдээ татвараар мэргэшиж байж, татварын нюансыг нь ойлгож байж татвар төлөгчдөө хамгаалдаг, татвараас зайлсхийж зугтах юман дээр нь бас оновчтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хяналт тавьдаг байх хэрэгтэй.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 1 минутаа гүйцээгээд авчихъя.

П.Сайнзориг: Хүүхдийн кэйсүүд дээр прокурорууд бас мэдрэмжтэй хандах асуудлууд байдаг. Тийм ээ.

Тэгэхээр ер нь прокурор шиг мэргэшүүлэх асуудал дээр та ямар байр суурьтай байдаг вэ? Яг дагнаж мэргэшүүлэх асуудлыг прокурорын байгууллага одоо ямар байдалтай хийж байгаа вэ?

Тэгээд хамгийн нэг чухал санаа байгаа. Б.Энхбаяр гишүүн бүлгийн хурал дээр ч хэлж байсан даа. Би ч бас үүнийг өдөр хараад сууж байсан. Яг энэ гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл буюу энэ криминологийн судалгааг прокурорын байгууллага маань дэргэдээ институц ажиллуулах бололцоо бүрдсэн. Үүнийгээ тогтмол сайн хийж, эргээд Засгийн газрын байгууллага болох Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын Их Хуралтайгаа хамтарч ажиллаж, яг сэтгэл хөөрлөөр биш, яг бодитой судалгаа, үндсэн шалтгаан нөхөл рүү нь чиглэсэн байдлаар энэ ялын бодлого, гэмт хэргийн шинжийг тодорхойлох асуудлыг хийдэг энэ зүйл рүүгээ эргээд хэдүүлээ бас нэг анхаарал хандуулмаар

байгаа юм. Энэ дээр бас таны байр суурь ямар байдаг вэ гэдэг зүйл дээр товч товчхон хариулж өгөөч ээ гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Б.Жаргалсайхан: П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Асуусан асуултын сүүл хэсгээс нь би эхэлье.

Прокурорын байгууллагад ажиллаж байгаа прокурорыг мэргэшүүлэх тал дээр сүүлийн жилүүдэд анхаарч ажиллаж байгаа. Тухайлбал, авлига, албан тушаал, мөнгө угаахтай холбоотой хэрэг дээр прокуроруудыг мэргэшүүлж байгаа.

Энэ мэргэшүүлэх ажлын нэг хүрээнд Улсын Ерөнхий прокурорын хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтэст авлига, албан тушаал, мөнгө угаах хэргийг хянан шийдвэрлэх албыг байгуулсан. Энэ албан дээр одоо мэргэшсэн прокурорууд ажиллаж байна.

Дээр нь Нийслэлийн Прокурорын газар дээр яг энэ ажлыг хариуцсан нэг хэлтсийг байгуулж ажиллаж байгаа.

Нийтдээ 27 орон тоо энэ чиглэлээр нэмж, нийслэл, дүүргүүдэд яг энэ чиглэлийн ажлыг мэргэшүүлж байгаа. Бидний анхны эхний мэргэшүүлж байгаа нь авлига, албан тушаал, мөнгө угаахтай холбоотой хэргүүдээр мэргэшүүлж байгаа юм.

Ер нь цаашдаа хэргийн төрөл бүрээр, тодорхой чиглэлээр мэргэшүүлнэ. Энэ чиглэлээр таны ярьсан бага насны хүүхэдтэй холбоотой хэргүүд дээр прокуроруудыг тусгайлан томилж, яг энэ төрлийн хэргийг хянаж, шийдвэрлэдэг ийм прокуроруудыг томилсон.

Цаашдаа амьдралаас урган гарч байгаа энэ чиглэлүүдээр ер нь прокуроруудыг мэргэшүүлэх чиглэл рүү явж байгаа. Миний гол барьж байгаа зүйл, би өмнө нь ч хэлсэн, хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн тусгай салбаруудын өндөр мэдлэгтэй, ёс суртахуунтай ийм л хүмүүс манай прокурорын байгууллагад ажиллах ёстой юм.

Дараагийн нэг асуудал, цахимтай холбоотой асуудал Та ярьж байна. Зөрчилтэй холбоотой цахимын нэгдсэн сан бид байгуулсан. Одоо ингээд бүх байгууллагуудаар туршилтын журмаар ажиллаж байна. Удахгүй энэ ашиглалтад орно. Эндээс нэгдсэн бүртгэлийн сан бий болно. Үүнийг дагаад цахим хавтаст хэрэг эрүү дээр ч, зөрчил дээр ч цахим хавтаст хэргүүдийн үйл ажиллагаанууд эхлэх юм.

Үүний эхлэл болгож Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад манай 6 гол яг энэ ажлыг хариуцсан хүмүүс очиж цахим хавтаст хэрэгтэй нь танилцаад ирсэн.

Энэ дээр мөн шүүх өөрөө цахимжиж байна. Цахимчидтай холбоотой прокурор, мөрдөх байгууллагуудыг холбох ажлууд яг хийгдэж байна. Цахим сантай холбогдуулж яг энэ чиглэлийн ажлыг хариуцдаг 10 мянга орчим эрх бүхий албан тушаалтанд сургалт оруулсан. Энэ чиглэлээр ажиллахад бэлтгэж байгаа.

Прокурорын хуульд өөрчлөлт оруулах, хувцас формтой гэдэг асуудал их л олон жил бас л яригддаг. Эргээд прокурорын байгууллагад энэ дүрэмт хувцастай байх асуудал нь бас л их түүхийн хувьд их олон жил яригдаж байж бий болсон зүйл. 1978 онд яригдаж байгаад намын тэр тухайн үеийн намын төв хороо шийднэ гэж явж байгаад 1996 онд анх хувцас формтой болсон.

Гэхдээ энэ хувцас формыг дан дүрэмт хувцсаар нь биш шүүх дээр өмгөөлөгч, прокурор өмсдөг өмсгөлтэй. Шүүгч хүн яг ижил мэтгэлцээний зарчмыг үндэслэж шийдвэрлэхэд дүйхүйц, олон улсын жишигт л нийцүүлсэн ийм зүйлийг бид хийсэн юм.

Ёс зүйн зөвлөлтэй холбоотой тийм асуудлууд бий. Тэгэхдээ бид эхлээд л явж байгаа. Жишээ нь, прокурорыг томилох журам батлагдсан. Тэр журам дээр.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон гүйцээгээд хариулъя.

Б.Жаргалсайхан: 8 төрлийн байгууллага прокурорыг томилох, прокуророос шалгалт авч яг хууль зүйн буюу хуульчийн сонгон шалгаруулалт шиг шалгалт авч ажиллах ийм комиссыг бий болгож байгаа юм.

Энэ хүрээнд Ёс зүйн зөвлөлтэй холбоотой асуудлыг мөн шийднэ. Дан ганц прокурор өөрсдөө ёс зүйгээ яриад суудаггүй.

Гэхдээ энд нэг л зүйл байдаг. Би өмнө нь ч бас хэлсэн. Ёс зүйн зөвлөлд мэргэжлийн хуульч байхгүй бол энгийн аль ч байгууллагын хүн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулдаг прокурорын ийм лицензтэй, ийм хүнтэй мэтгэлцэж, ёс зүйг нь зөрчсөн, үгүйг шийднэ гэдэг бас асуудалтай байдаг.

Тийм учраас бид боломжит хэлбэрээр шийднэ гэсэн ийм л зорилготой ажиллаж байгаа. Хариулж дууслаа.

Д.Цогтбаатар: Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Б.Заяабал гишүүнээр тасаллаа Х.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Хэлэлцэж байгаатай холбоотой асуудлаар гурван үг хэлмээр байна.

Нэгдүгээрт нь, түрүүн хуулийн асуудал дээр Г.Занданшатар дарга хэллээ. Энэ хуулийн асуудлыг Хууль зүйн байнгын хороо бас анхаарч Улсын Их Хурал дээр нэг мөр болгохгүй бол томилж байгаа хэсэг дээрээ ч, томилогдоод явж байгаа хүн дээрээ ч ардаа нэг тийм гохтойгоо үлдчих гээд байгаа юм шиг харагдаад байгаа шүү.

Тийм учраас Үндсэн хуулийн цэцийн шийдвэр байна уу, эсвэл хууль зүйн бодлого байна уу, ямар нэгэн байдлаар энэ нэг тайлбарлахад төвөгтэй, эсвэл зөрчилдөөнтэй байгаа асуудлаа ойрмогхон хурдан шийдээрэй гэж хэлж байгаа юм. Шийдэхгүй бол цаг мөнх энэ нөхцөл байдлаараа байхгүй. Юм өөрчлөгдөнө. Ард гох дэгээ үлдвэл, хуулийн асуудлыг үлдвэл аль альдаа, ажил хийж байгаа хүндээ ч садаатай, хууль тогтоож байгаа хүмүүстээ ч бас түвэгтэй.

Хоёрт нь, прокурор дээр том шинэтгэл хийхэд нэг зарчим ийм байгаа. Уг нь 2012 онд орж ирсэн юм. Тэгээд бүрэн хэрэгжиж чадахгүй манайд бүр бүдгэрээд алга болчихлоо. “Шүүхэд төлөөлөх эрх” гэж. Шүүхийн өмнө прокурор, шүүгч, өмгөөлөгч хоёрыг яг ижил хэмжээнд эрх мэдэлтэй байлгадаг мэргэжлийн хувьд мэргэжилдээ үнэнч, хариуцлагатай, хуулийн дагуу ажилладаг болгодог энэ механизм байгаа юм.

Би нэг газар явж байгаад шүүхэд төлөөлөх эрхээ алдсан прокурортой таарч үзсэн юм. Энэ тэгээд юу хийх вэ гэсэн чинь энэ шүүх рүү орохгүй, баар давж алхахгүй. Тэгээд прокурорын байгууллагад архив хавьцаа захиргааны л ажил хийх байх. Жилийн дотор шүүхэд төлөөлөх эрхээ буцааж авч чадахгүй бол ийм хүнийг прокурор тэжээх албагүй. Жилийн дараа халах байх гэж.

Энэ систем яаж ажиллаж байна вэ гэхээр прокурор дээрээ байгаа даргадаа үнэнч байх тухай биш. Шүүхэд ажлаа шударга, үнэн, хуулийн дагуу хийдэг байх тухай яриа юм.

Прокурорын дотоод ёс зүйн системийн тухай яриа биш. Шүүхэд мэргэжилтэн прокурор хүн нь мэргэжлийнхээ тэр ур чадварыг гаргаж чадаж байна уу, үгүй юу гэдэг яриа л энэ прокурорын байгууллагын гол үнэ цэнэ.

Тэгэхээр энэ чиглэл рүү бас томоохон өөрчлөлт хийх байх.

Нэгэнт шүүх дээр ажиллана гэдэг дахиад нэг том зарчмын юм байгаа. Бид нөгөө мөн чанар, агуулгаас илүүтэй хэлбэрдэлтэд их дуртай үндэстэн юм. Прокурорыг дүрэмт хувцастай болгоод цэргийн юм шиг болгох гэж нэг хэсэг оролдсон. Одоо ч Та бүхэн энэ хувцсандаа дуртай байгаа байх.

Шүүх рүү орохдоо өмгөөлөгч нар маань нөмрөг өмсөж ордог болчихсон. Бас тэд нар түүндээ дуртай байгаа юм шиг байна лээ. Гэхдээ Үндсэн хуулийн байгууллынхаа хувьд шүүхэд “прокурор яллагч”, “өмгөөлөгч” хоёр нөмрөг өмсөж ордог улс чинь түрүүн таны хэлсэн англи-сагсон маягийн улсууд буюу эзэн хаант улсууд. Хааны шүүхэд ирж байгаа учраас нөгөө ихэс дээдсийн шүүхийг хүндэтгэж тусгай өмсгөл өмсдөг. Бүгд найрамдах буюу иргэний улсад хуульчид нь ийм өмсгөл өмсдөггүй. Иргэнийхээрээ байх ёстой.

Тийм ч учраас цаашид шүүхийн томоохон шинэтгэл зоригтой хийе гэвэл шүүхэд нэг тийм феодал маягтай, хаан маягтай байдаг энэ соёлыг Бүгд Найрамдах Монгол Улсад байхгүй болгох ёстой. Шүүх өөрөө иргэний зохион байгуулалттай.

Тийм учраас прокурор нь ч байна уу, өмгөөлөгч нь ч байна уу ямар нэгэн байдлаар тусгай өмсгөл хэрэгсэл өмсдөгөө болиод гадуур гудамжинд ямар хувцас өмсөх нь тэдний л асуудал л байх. Хувьдаа худалдаж авах мөнгө нь хүрээд төсвөөс захирах зардал нь байж байвал ямар хувцас өмсөх бол тэдний л асуудал байгаа.

Шүүх бол Үндсэн хуулиар Монгол Улсад Бүгд Найрамдах Улс байгаа бол иргэний шүүх байх ёстой. Иргэний зохион байгуулалттай. Энэ агуулга дээр бид зоригтой алхам хийх ёстой байх. Шүүх төлөөлөх эрхийн хувьд шүүхэд өмсөх өмсгөлийн хувьд хэлбэр дүрсийн хувьд, агуулгын хувьд жижигхэн юм шиг боловч энэ бол цэвэр нөгөө шүүх эрх мэдлийн хамгийн чухал мөн чанарыг амилуулдаг хэсэг байгаа юм.

Тэгээд Хууль зүйн байнгын хороо саяын дурдсан гурван юман дээр бас анхаарч ажиллана биз дээ гэж бодож байгаа юм.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Би Х.Тэмүүжин гишүүний зарчмын санал байр суурьтай санал, нэг байгаа бөгөөд дэмжиж болон үргэлжлүүлж бас хэдэн санал хэлье гэж бодож байна.

2021 онд Шүүхийн багц хууль шинэчлэгдэж байх үед Шүүхийн хууль бол шударга ёсны тогтолцооны 10 хувь л юм. Бид шударга ёсны тогтолцоо ганцхан шүүхийн хууль баталснаар шийдчихгүй. 90 хувь нь мөрдөх болон прокурорын хяналтын үе шаттай холбоотой шинэчлэл хийгдэж байж энэ бүтэн болно гэдэг зүйлийг хэлж байсан.

Үнэхээр хэрэг шалгагдаж байгаа хэрэг учралын 90 хувь нь шүүх рүү явдаггүй буюу прокурорын үе шатад хянаж, хэргийн хувь заяа шийдэгдэж байдаг. Тэр утгаараа шударга ёсны тогтолцооны маш том цөм хэсэг прокурорын байгууллага байдаг.

Сүүлийн үед харагдаж байгаа нэг тогтолцоо бол шүүх рүү бүх зүйлийг зааж чиглүүлэх байдлаар хариуцлагаас бултах, ард нь нуугдах ийм хандлагад мөрдөх алба дадах ийм байдал их анзаарагдаж байгаа.

Урьдчилж хэвлэлээр хэн нэгэн хүний гэм буруугийн асуудлыг түгээдэг. Нийгэм, олон нийтийг энэ хүн аль эрт гэм буруутай мэт ойлголтыг төрүүлдэг. Ингээд ичсэн хүн ална гэдэг шиг энд нь бантаж прокурор ерөөсөө бушуухан шүүх рүү шилжүүлдэг. Өөрсдөөсөө ингээд хариуцлагыг хүлээхгүй байх ийм хандлагад автчих вий гэдэг дээр би болгоомжилж байна.

Хууль тогтоогчдын хувьд тодорхой хэрэг учралын асуудлаар прокурорын байгууллагад нөлөөлөх, асуух, зааж чиглүүлэх ийм зүйл байхгүй. Тэр ч утгаараа сая жишээлбэл Н.Алтанхуяг гишүүн том хүн учраас тодорхой хэрэг учрал бол ярихгүй гараад явчхаж байна.

Энэ Н.Алтанхуяг гишүүний холбогдоод байгаа Хөгжлийн банкны хэргийг би прокурорын мянга гаруй хуудас яллах дүгнэлтийг уншиж үзсэн. Би яагаад уншсан бэ гэхээр өөрөө Хөгжлийн банкны гэх сонсголыг 3 сарын турш Улсын Их Хурал дээр хийсэн. Энэ дээр маш олон үйл баримт, нотлох баримтуудыг яригдсан учраас эндээс ямар асуудал нь шүүх рүү шилжиж байгаа юм бол, ямар нь хэрэг биш болж бас үлдэж байгаа бол гэдгийг их анхааралтай үзсэн юм.

Тэгээд тэмдэглэж үзэж байхад надад нэг ийм сонин юм анзаарагдсан нь тэр 80 хэдэн хүнээс 40 гаруй нь Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн гэх хүмүүс байсан. Эндээс 14, 15 орчим хүний хэрэг нь нэр нь солигдоод яллах дүгнэлт нь COPY FAST яваад байсан. COPY FAST. Өөрөөр хэлбэл түүн дотор хэдэн үгийг алдаатай бичсэн байгаа байхгүй юу. Яг тэр алдаатайгаа тэр 14, 15 хүн дээр яг адилхан яллах дүгнэлт дээр яваад байгаа байхгүй юу. Нөгөө үсгийн алдаатайгаа. Энэ чинь шууд компьютер дээр COPY and FAST хийгээд байна гэсэн үг байхгүй юу.

Тэгтэл тэр хүн болгоны хэрэг учрал, нотлох баримтууд гэдэг чинь өөрөө өөр өөр байгаа шүү дээ. Энэ хүний хувь заяа яригдаад байгаа байхгүй юу. Гэм бурууг шүүх дээр аваачиж байгаа хэргийн тухай яриад байгаа байхгүй юу.

Тэгээд тэр олон мянган хуудас яллах дүгнэлттэй хэргийг арван хэдхэн хоногийн дотор прокурор шүүх рүү шилжүүлчхаж байгаа байхгүй юу. Би бол 3 сар нотлох баримт үзэж байсан хүн. 3 сар шүү. Прокурор 10 хоног.

Тэгэхээр энэ.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 1 минут нэмж өгье. Б.Энхбаяр гишүүнд.

Б.Энхбаяр: Би энд юу хэлэх гээд байна вэ гэхээр тухайн прокуроруудыг тухайн хэрэгт би нөлөөлөх гэж байгаа тухайд биш. Энэ Улсын Дээд шүүхээр

орчихсон хэргийн тухайд би ярьж байгаа учраас, эцэслэчихсэн хэргийн тухай би өөрийнхөө байр суурийг хэлж байгаа гэж үзэж байгаа.

Жишээлбэл, манай Түр хорооны сонсгол дээр тодорхой хүний гэм буруугүй гэдэг нотлох баримт яригдсан байдаг юм. Тэрийг би хууль хяналтын байгууллагууд харсан юм болов уу, үзсэн болов уу. Би ч ярьж болохгүй шүү дээ. Нөлөөлж болохгүй.

Ингээд харахаар жишээлбэл тэр газрын захирал гэх үү, тэр мэргэжилтэн гэх үү, тэр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний гэм буруугүйг нотолсон баримт жишээ бол тэнд очоогүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр энд юу хэлж байна вэ гэхээр одоо цаашдаа парламентын түвшинд ч тэр, бид шүүхийн хурлуудыг нээлттэй болгодог болчихсон. Энэ өөрөө нөгөө прокуроруудыг аягүй их тийм бас тэр яллах зүйлүүдийг хэр хариуцлагатай, хэр нотолгоотой ярьж байгааг ард түмнээрээ харах бололцоог олгосон байгаа юм. Тийм.

Д.Цогтбаатар: П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би нэр дэвшиж байгаа, Улсын Их Хурал дээр зөвшилцөхөөр орж ирсэн Б.Жаргалсайхан прокурорыг дэмжиж байгаа.

Мэдээж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавихаас гадна прокурорын байгууллагын институцийн хувьд цаашдаа бэхжүүлэх буюу тэр үйл ажиллагааг ил тод, илүү их цахим буюу энэ зүйл рүүгээ оруулах талд нь хийж хэрэгжүүлж байсан ажлаа дуусгаасай гэж хүсэж байгаа юм.

Ингэж байж үүний цаана хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хавтаст хэргүүд, жижиг сажиг нотлох баримтууд үрэгдсэн, үрэгдээгүй гэдэг маргаан гарахаас зайлсхийх, орон зайнаас үл хамаараад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч этгээдүүд хэргийн материалтайгаа танилцах, өөрөө гомдол, мэдээллээ гаргах энэ бүх бололцоо бүрдэх юм.

Тэгэхээр өнөөдөр 500 гаруй л прокурор ажиллаж байгаа. Угаасаа улсын хэмжээнд маш ачаалалтай ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ цахимжилтын цаана прокурорын байгууллагын яг хувь албан тушаалтан, прокурорын үйл ажиллагааг хөнгөвчлөхөөсөө гадна энд оролцож байгаа иргэдийн, хуулийн этгээдийн, тэдгээрийг өмгөөлж байгаа өмгөөлөгчдийн үйл ажиллагааг ч хялбарчлах, тэгээд үүний дараа шударгаар хэрэг маргаан хянан шийдвэрлэгдэх бүрэн бололцоо бүрдэх юм.

Тэгэхээр Б.Жаргалсайхан прокурорыг энэ эхлүүлсэн ажлыг дуусгаж ард нь гараасай гэдэг зүйлийг би хүсэж байгаа юм.

Дээрээс нь прокурорыг мэргэшүүлэх асуудал байгаа. Сүүлийн үед прокурорууд асуудлууд дээр бид хэд бас анзаарвал илүү их зохион байгуулалттай, нарийн төвөгтэй санхүүгийн хэд хэдэн үе шатыг дамжсан схем бүхий гэмт хэргүүд явна. Гэрээгээр халхавчилсан, иргэний маргаанаас үл ялиг шинжээр ялгагдах ийм гэмт хэргүүд маш их байгаа.

Яг энэ дээр нарийн нюанстай прокуроруудыг мэргэшүүлж тэр санхүү, эдийн засгийн чиглэлээр мэргэшүүлэх. Дээрээс нь мэргэшүүлэх тэр асуудал маань тэр хүнтэй яг харьцах буюу тэр хүүхдийн эрхийг нюанстай харьцах. Үүнийг маш энгийнээр харах ёстой. Жишээ нь, бусад орон дээр яг энэ прокурорын байгууллагын үйл ажиллагаа, мөрдөгчийн үйл ажиллагааг үзүүлдэг кинонууд хүртэл байдаг. Тэнд иргэдийг авчирлаа гэхэд таныг цагдан хорих гэж байна. Танд янз бүрийн харшилтай зүйл бий юу, хоол унд бий юу. Харшлын талаар ч гэдэг юм уу, эсвэл энэ тогтмол хэрэглэдэг эм ууж байгаа заавар байгаа юу ч гэдэг юм уу, наад захын хүн рүү ордог энэ зүйлүүдээсээ прокурор шийдвэр гаргахдаа асуудаг, мөрдөгчтэйгөө хамтарч шүүх дээрээ бас энэ асуудлаа тавьдаг, үүнээсээ мэргэших ёстой шүү гэдэг зүйлийг би хэлмээр байгаа юм.

Тэгээд үүнийг хийж чадвал прокурорын байгууллагын иргэдийн итгэлийг авах тэр асуудал цаашдаа илүү нэмэгдэнэ.

Тэгээд прокурорын ёс зүйн зөвлөл, хувцас форумын асуудлыг би сая асуулт асуусан. Үүнийгээ ч би бас хөндөж тавина. Тэгээд үүнийгээ сайжруулах асуудлууд байна.

Дээрээс нь энэ зүйл засагдсан байх гэж би найдаж байгаа. Прокурорын байгууллагууд дээр бас нэг яригддаг зүйл юу вэ гэхээр шүүхээс хэрэг буцвал эргээд прокурорууддаа жоохон хариуцлага тооцдог, ажлын үзүүлэлт доошилсон гэдэг юм уу, ажлын үзүүлэлт муу гэдэг байдлаар бас нэг арга хэмжээ авчих гээд байдаг ийм журмууд үйлчилдэг. Үүнээсээ бид ер нь татгалзах хэрэгтэй. Заавал прокурор гэдэг хүн чинь шүүх дээр орохоороо яллах талыг барих биш. Аль болохоор яллах болон цагаатгах аль аль талын нотлох баримтыг гаргаж, хэргийг зөв хуулийн хүрээнд л боож шүүхэд танилцуулж эцэслэн шийдүүлэх асуудал байдаг.

Тэгэхээр бид хэдийн сэтгэхүйн хандлага илүү их яллах функцээ бариад яваад байдаг. Үүнээсээ бид гарч сэтгэлгээний өөрчлөлтүүд хийх зайлшгүй шаардлага байгаа юм.

Тэгээд ер нь прокурорын байгууллага өөрөө эргээд хэр ажиллах, хэр үр нөлөөтэй ажиллахаас Монгол Улсад хууль ёс бэхжих, Үндсэн хууль ёс бэхжих асуудал шийдэгдэх юм. Тэгээд танд амжилт хүсье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Б.Заяабал гишүүний микрофоныг өгье.

Б.Заяабал: Баярлалаа.

Тэгэхээр хууль сахиулах, хүний эрхийг хамгаалах, олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, хуулийг зөв хэрэглэхэд мэдээж хууль зүйн мэдлэг, мэргэшил байхаас гадна ажлын туршлага, тэр дундаа хамгийн чухал нь амьдралын туршлага хамгийн чухал гэж үздэг. Миний хувьд. Олон улсад ч гэсэн шүүгч нарыг насан туршид нь энэ албанд томилж явдаг нь үүнтэй холбоотой болов уу гэж боддог.

Б.Жаргалсайхан прокурорын талаар тараагдсан материалыг аваад үзэх юм бол би бас л яг энэ шаардлагыг хангасан хүн юм байна даа. Хувь хүнийхээ бэлтгэл талаасаа гэдэг байдлаар харагдаж байгаа юм л даа. Материалаас нь.

Аймгийн прокурорын байгууллагад үндсэндээ 12 жил ажилласан байна. Тээврийн прокурорын газарт 11 жил ажилласан байна. Улсын Ерөнхий прокурорын байгууллагадаа бас 14 жил ажилласан байна. Энэ агуулгаараа аваад үзэх юм бол яах аргагүй энэ хүн ажлын туршлагатай, амьдралын туршлагатай хүн байна гэдэг нь харагдаж байгаа юм.

Тэгэхдээ прокурор хүний хамгийн чухал анхаарах ёстой зүйл бол нэгдүгээрт хүний эрхийн асуудал, эрх чөлөөний асуудал, нийтийн ашиг сонирхлын асуудал хамгийн чухал асуудал. Хамгийн чухал асуудал.

Өнөөдөр та энэ ордны сэтгүүлчдэд ярилцлага өгөхдөө бас хэлсэн юм шиг байна лээ. Би сая сошиалаас л олж харлаа л даа. Хүний эрхийг хангах үүднээс иргэдийг аль болох цагдан хорихгүйгээр хэргийг нь шийдэхэд онцгой анхаарч ажиллах болно, ажиллаж ирсэн гэдэг ийм үг хэлсэн байна лээ. Надад энэ үг үнэхээр таалагдаж байгаа. Би өөрөө энэ Үндсэн хуульд зааснаас өөрөөр хүний эрхийг бусад аргаар хүний эрхийг хориглох, хязгаарлахын эсрэг байдаг ийм хүн. Энэ ч агуулгаараа өнөөдөр Хууль зүйн байнгын хорооны гишүүнээр ажиллаад явж байгаа.

Тэгээд саяхан бас та энэ олон нийтийн, монголчууд бүгдээрээ л шуугьсан. Энэ “Ноорог”-ийн залуучуудын асуудал байна. Харанхуй шөнө бүгдийг нь баривчилж, хойшлуулшгүй ажиллагаа гэдгээр баривчилж аваачсан. Прокурорт үргэлжлүүлж хорихтой холбоотой санал илгээхэд прокурор тэрийг нь хүлээж аваагүйгээр гаргасан. Нийгэмд ямар хэмжээний асуудал үүсэв. Тэдгээр залуусаар төлөөлүүлээд ер нь хүний эрх ямархуу хэмжээнд Монгол Улсад хангагдаж байгаа юм бэ гэдэг ийм асуудал хүртэл яригдсан.

Энэ дээр прокурорын байгууллага зөв шийдвэр гаргаж, олон нийтэд мэдэх эрхийг нь хангахад, хүний эрхийг хангахад онцгой үүрэг гүйцэтгэсэн гэж би үнэлж байгаа юм.

Прокурорын байгууллага мэдээж албан үүргээ гүйцэтгэхдээ хараат бус бие даасан байдлаар гүйцэтгэх ёстой. Хэрэг маргааныг шийдэх ярвигтай ажил.

Ялангуяа улс төрчид оролцсон авлига, албан тушаалын хэргүүд маш хүндрэлтэй асуудал байгаа.

Өнгөрсөн 6 жилийн таны ажиллах хугацаанд нэлээдгүй нийгмийг донсолгосон маш их олон хэргүүд шийдэгдсэн. Шийдэгдээгүй явж байгаа хэргүүд ч бас нэлээдгүй бий. Нийгэм бүхэлдээ шударга ёсыг их шаардаж байгаа. Энэ цаг үед энэ олон хэргүүдийг шүүхэд шилжүүлж, олон нийтийн анхаарлын төвд авчирч, бас ингээд хэрэгжүүлээд явж байгаа.

Мөн үргэлжлүүлэн та прокурорын байгууллагыг цахим болгохтой холбоотой, ил тод нээлттэй байдлыг нь хангахтай холбоотой асуудалд бас онцгой анхаарч анхаарал хандуулж ажиллана гэж хэлж байна. Энэ бүх байдлыг аваад үзэхэд таны ажил зөв явж байсан юм байна гэж үзэж байгаа.

Саяхан бид Авлигатай тэмцэх газрын даргыг бас 6 жилийн хугацаагаар нь сонгож томилсон. Энэ дээр яригдаж байсан өнгөрсөн 6 жилийн хугацаанд та бас өглөө намын бүлэг дээр ярьж байсан. Нийтдээ 11.6 их наяд төгрөгийн авлигалаас үүссэн хохирлыг төлүүлсэн байгаа. Төлүүлсэн гэж ярьж байсан. Энэ бол яах аргагүй иргэдийн хүсэж байгаа шударга ёсны хүсэмжээ гэдгийг энд хэлье.

Ингээд дэлхийд бас дайн тулаантай, дэлхийн хүчний харьцаа тодорхойгүй байгаа ийм цаг үед Монгол төрийн тэргүүн, Монгол Ардын намаас нэр дэвшиж Ерөнхийлөгч болсон хүн, өмнө нь.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Б.Заяабал гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

Б.Заяабал: Өмнө нь Ардчилсан намаас Ерөнхийлөгч сонгогдож Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүн таныг анх удаа нэр дэвшүүлж оруулж ирж ажиллуулж байсан.

Ингээд хоёр дахь удаагаа таныг дэлхийн нөхцөл байдал хүнд байгаа үед Монгол төрийн тулгуур болсон чухал албан тушаал дээр үргэлжлүүлж ажиллах ёстой гэдэг байдлаар нэр дэвшүүлж оруулж ирснийг би дэмжиж байгаа гэдгийгээ илэрхийлье.

Ингээд эцэст нь үе үеийн Хууль зүйн сайд нарын хэлсэн үг байна. Хууль зүйн яамны гал тогоог хариуцаж ажиллаж байсан, энэ Хууль зүйн салбарыг толгойлж ажиллаж байсан эдгээр гишүүдийн саналтай би адил саналтай байгаа. Та энэ саналуудыг ажилдаа тусгаж ажиллаарай гэдгийг Танд илэрхийлж хэлье. Танд амжилт хүсье.

Д.Цогтбаатар: Гишүүд хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан үг хэлж дууслаа. Би нэг цөөхөн хэдэн санаа хэлээдэхье.

Нэг зүйлийг нэр дэвшигчид хэлмээр байна юу гэвэл та зоригтой ажиллаарай. Одоо бол та шийдэмгий, тултлаа, ямар ч юмнаас ухралгүйгээр ажиллах ёстой.

Би энэ дээр юу хэлэх гэж байна гэхээр ялангуяа улс төрийн салбарт юу ажиглагддаг вэ гэхээр сошиалаар, түрүүн Б.Энхбаяр гишүүн бас хэлж байна лээ. Сошиалаар баахан юм хөөрөгдөж хөөргөчхөөд, энэ болохгүй, бүтэхгүй юмыг улс төрийн хүрээнийхэн л хийдэг. Улс төрийнхөө тэмцэлд явж байгаад сүүлдээ халуураад баахан юм явуулчихаад, та нарыг гарцгүй болгоод, дараа нь хууль шүүхийнхэн яахыг харъя гээд. Та нар яахыг нь харуулж байна. Буруугүй. Үнэхээр дотоод итгэл үнэмшилд чинь харваас зүгээр сошиалаар нүдэж байгаад тэгээд та нараар ямар нэгэн юмыг үндэслэлгүйгээр буруутгах гэж байгаа бол тэгэхгүй ээ гэж хэлээд, энэ улс чинь хуультай, би тэр хуульд л захирагдана гээд та айхгүй үг хэлж сурах ёстой.

Би барууны шүүх, прокуроруудын нэг гайхамшигтай юм надад юу санагддаг вэ гэхээр олон нийт нь ёстой доргичихсон байгаа, тэнд бөөн улс төржүүлээд явчихсан байгаа юмыг хууль чинь бол яг үндэслэлтэй. Харж байгаа биз. Хууль нь яг ийм байна. Би ингэж л гаргана. Би хуульд л захирагдана. Гүйцээ.

Тэгэхээр ийм байдлаар Та зоригтой ажиллаарай. Буруу хийсэн хүмүүс байвал шийтгэлээ хуулийн ямар ч гарцаагүйгээр хүлээдэг байх ёстой. Буруу юм хийгээгүй байвал тэндээс яаж ч балбаж нүдсэн бай тэнд хууль гэдэг юм нь иргэнээ хамгаалдаг байх ёстой. Ингэж байж шударга ёс гэдэг чинь тогтох юм.

Тэгэхээр энэ дээр би таныг урамшуулж, зоригжуулж ийм үг хэлмээр байгаа юм. Хууль зүйн байнгын хорооны зүгээс, Улсын Их Хурлын зүгээс ч дэмжиж ажиллана гэж би хэлмээр байна.

Энэ нэг зүйл байгаа юм. Сүүлийн үед ингээд ярихлаар бид авлигатай тэмцэж байгаа талаар ярихад тоо ярьж байна. Динамик үзүүлэлт маш их өсөж байгаа юм. Тэгээд үүнийг бид сайн гээд байгаа юм. Үнэн. Гэм хийсэн хүмүүс байвал хэд ч байсан тэд нар хариуцлага хүлээх ёстой. Тэгэхдээ хуулийн хэрэгжилтийн цаад зорилго чинь юу вэ гэхээр эцсийн дүндээ тэр авлига гэдэг үзэгдэл буурах ёстой. Одоо нэлээн хэдэн жилийн дараа авлигачдын тоо хэвэндээ байгаад, шийтгэлийн тоо хэвэндээ байгаад байвал нөгөө хууль чинь урьдчилан сэргийлэхгүй, авлига гэдэг юм чинь буухгүй байгаад байна гэсэн үг.

Тэгэхээр цаад талын үзүүлэлт бол тэр тоо алсдаа хууль үйлчлээд, энэ хуулийн үйлчлэлийн хүрээнд авлига гэдэг үзэгдэл чинь өөрөө багасаад, энэ нь багасах юм бол тэр шийтгэл, гэсгээд л авч байгаа хүмүүсийн тоо багасах ёстой. Энэ үр дүнгээ бид тооцож ажиллах ёстой гэж би бодож байгаа. Ингэх юм бол нөгөө хүнлэг, хүний эрхийг дээдэлсэн хандлага маань өөрөө зонхилж байна гэсэн үг.

Тэгэхээр энэ дээр хууль үйлчилдэг, урьдчилан сэргийлдэг энэ тогтолцоогоо бий болгож авлига гэдэг үзэгдэл өөрөө буурах ёстой. Түүнийгээ бид бодолцмоор байгаа юм. Яагаад гэвэл олон жилийн дараа ч гэсэн өө тэдэн мянган хүнийг аваачаад хийчихсэн гээд суугаад байх юм бол тэр авлигатайгаа бид системийн хувьд бүхэлдээ, Их Хуралтайгаа, прокурор, цагдаа, АТГ, шүүхтэйгээ тэмцэж чадахгүй байна л гэсэн ийм үзэгдэл, улсад тийм дүн тавигдана гэсэн үг.

Тэгэхээр тэрийгээ бид бодолцмоор байгаа юм. Тоо гэдэг дээрээ тэгэхээр үүнийгээ анхаарч ажилламаар байна гэж бодож байгаа юм.

Зүгээр би нэг хамаагүй санал хэлье. Та нар маань бодоод үзээрэй. Танай салбарт “Эй Ай”-ийг нэвтрүүлмээр байгаа юм. Одоо энэ хиймэл оюун ухааныг. Тэгээд болдог бол. Би зүгээр төсөөлж байна шүү. “Эй Ай” прокурор бий болгоод тэр нь танай дотоод хэрэглээний. Гадаад талдаа хэрэглэгдэх биш. Дараа нь прокурорууд энэ дээр дүгнэлтээ гаргахад яг тэр хэргийн материалууд нь өмгөөлөгчид нь жишээлбэл нөгөө өмгөөлж байгаа хүмүүсийнхээ материалыг танай платформ руу оруулчихсан байдаг. “Эй Ай” тодорхой. Энэ дээр бол яг л ийм дүгнэлт гарах юм байна. Хувь хүн субъектив ямар дүгнэлт гарч байна. Тэр их олон зөрөөд ирэх юм бол прокурор дээр энэ яагаад таных “Эй Ай” дээр ийм шийд гараад байхад таных маш олон ингэж зөрөөд байна гэдэг асуудал гарч ирэх юм бол дараа нь прокурорууд гаднаас ямар нэгэн нөлөөлөлгүй, намайг тэртээ тэргүй хэний ч нөлөөнд автахгүй “Эй Ай” бас давхар хянаж байгаа шүү гэдэг тэр болгоомжлол прокуроруудын толгойд төрөх тийм нөхцөл үүсэх байх.

Тэгэхээр тэрийг хөгжүүлэх, энэ чиглэлээр хэрэв та санаачилгатай сонирхож ажиллая гэвэл би “Эй Ай”-ийн чиглэлийн хүмүүстэй холбож өгөөд Хууль зүйн байнгын хорооноосоо үүнийг хөгжүүлэх гээд явах юм бол хуулийн салбарын маш том шинэчлэл бөгөөд манлайлал болж болох юм.

Тэгэхдээ үүнийг би зүгээр нээлттэй танд санал болгож ярьж байгаа. Энэ талаар та бас санаа бодлоо хэлээрэй.

Тэгээд эцэст нь нэг зүйлийг хэлэхэд одоо ингээд л Улсын Их Хурлын гишүүд дархан эрхтэй энээ тэрээ гээд. Би ийм юман дээр нэг л байр суурьтай байдаг.

Монгол Улсын иргэд дархан эрхтэй. Үндсэн хуулиараа. Тэр лүү хамаагүй угаасаа халдаж болдоггүй. Улсын Их Хурлын гишүүдийн тэр дархан эрх иргэн хүний дархан эрхээс давсан байж болохгүй. Яг Эрүүгийн хуулийн асуудал дээр иргэн хүн яг тийм ижил түвшний дархан эрхтэй байх ёстой шүү. Үүнийгээ бид тал талдаа анхаарч явах ёстой.

Тэгэхээр таны хараа хяналтад “монгол хүний эрх чөлөө” байгаа шүү гэдгийг би хэлмээр байна. Тэгээд санал хураалт руу явъя.

Тэгээд Монгол Улсын Ерөнхий прокурорын албан тушаалд Банзрагчийн Жаргалсайханыг томилох асуудлыг Монгол Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр ирүүлсэн Ерөнхийлөгчийн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

68.0 хувиар дэмжигдлээ.

Тэгээд Б.Пүрэвдорж гишүүнийг дэмжсэнээр тооцож бүртгээрэй. Ингээд санал дэмжигдлээ.

Монгол Улсын Ерөнхий прокурорын албан тушаалд Банзрагчийн Жаргалсайханыг томилох асуудлыг Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр ирүүлсэн Ерөнхийлөгчийн саналыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал танилцуулна.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 2 цаг 20 минут үргэлжилж, 17 цаг 57 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД